

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Ховд аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх Аудитор:

Л.Галбадрах

Аудитын менежер:

А.Цэцэгсүрэн

Ахлах аудитор:

Д.Нарантуул

Аудитор:

Д.Мөнхтулга

Д.Балжинням

Д.Эрдэнэцэцэг

Ц.Аззаяа

Б.Дамчуубалжир

2018 оны 4 дүгээр сар

Уг тайланг Ховд аймгийн Аудитын газрын Цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70433061 дугаарын утас, 70433061 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Ховд аймгийн ЗДТГ-ыг Здавхар

Товчилсон үгийн жагсаалт2

Нэг. Ерөнхий зүйл

Аудит хийсэн үндэслэл, хугацаа.....3

Аудитын зорилт, хамарсан хүрээ.....3

Аудитын арга зүй.....3

ОН-ийнтөсвийн 2017 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал.....3

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт 4

Гурав: Шилэн дансны мэдээлэл..... 5

Дөрөв: Материаллаг байдал 5

Тав : Санхүүгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн талаар

Зургаа: Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

6.1. Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар6

Долоо: Авлагын бүртгэл, тайлагнал

7.1. Авлагын бүтэц, дамжуулан зээлийн авлагын талаар.....8

Найм : Бараа материалын бүртгэл, тайлагнал

8.1. Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар12

Ёс : Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

9.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар.....13

Арав : Өр төлбөрийн бүртгэл тайлагналын

10.1. Өр төлбөрийн бүтцийн талаар16

10.2. Урт хугацаат өр төлбөрийн талаар..... 18

Бусад асуудал

11.1. Улсын төсвийн санхүүжилтийн тусгай шилжүүлгийн талаар.....18-21

Арван хоёр : Төсөл сангийн бүтэц бүрэлдэхүүний талаар21-23

Арван гурав: ОНӨААТҮГ-ийн аудитын талаар23-28

Арван дөрөв: ОН-ийнТЕЗ-дын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар.....28-34

Арван зургаа: Аудитын санал дүгнэлтийн талаар.....35

Арван найм: Тайлант оны аудитын зөвлөмж.....36

Арван ёс: Ховд аймгийн 2016 оны аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан.....38

Товчилсон үгийн жагсаалт

АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АТӨЯХ	Авто тээврийн өөрөө явагч хэрэгсэл
БХС	Байгаль хамгаалах сан
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖМС	Жижиг мөнгөн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОН	Орон нутаг
ОНӨААТҮГ	ОН-ийн өмчит аж ахуйн төсөвт үйлдвэрийн газар
ОНӨҮГ	ОН-ийн өмчит үйлдвэрийн газар
ОНСНТ	ОН-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан
ОНХО	ОН-ийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийг хөгжүүлэх сан
САГ	Санхүүгийн аудитын газар
СС	Сангийн сайд
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СХС	Сум хөгжүүлэх сан
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон ОН-ийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТСГ	Төрийн сангийн газар
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл

Нэг. Ерөнхий зүйл

Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Ховд аймгийн аудитын газар Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэхь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн дагуу Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

ОН-ийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

ТЭЗ санхүүгийн нэгтгэсэн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт бөгөөд хамарсан асуудлууд болно.

Ховд аймгийн аудитын газар ОН-ийн төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу ОН-ийн төсвийн ерөнхийлөн захирагчдын 2017 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Аудитын арга зүй

ОН-ийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, хяналтын сорил, шинжилгээний горим болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв. Ингэхдээ санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болголоо.

ОН-ийн 2017 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал

ОН-ийн ТЭЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ УСНББОУС-д заасан зарчим, Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан нэгтгэх журам”-ыг баримтлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3, 6, 7.2 дэх заалтуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккрузл суурийг хэрэглэж, Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж гаргасан байна.

ОН-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах тайлангуудыг нэгтгэсэн байна. Үүнд:

- Төсөвт байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайлан 138
- Төрийн сангийн 2017 оны санхүүгийн тайлан 18
- ОН-ийн өмчит үйлдвэрийн газрын 2017 оны санхүүгийн тайлан 10
- Бусад 2017 оны санхүүгийн тайлан 10 /өрхийн эмнэлэгийн нэгтгэл, хувийн цэцэрлэгийн нэгтгэл, Засаг дарга, ОНХО, УТХО, Цэргийн дүйцүүлэх алба, Баянбулаг хүүхдийн зуслан, Лицей сургууль/
- Төсөл, сангуудын 2017 оны санхүүгийн тайлан 41 бүгд 217 байгууллагуудын тайлан нэгтгэсэн байна.

ОН-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй:

А. Үндсэн тайлан:	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
ОН-ийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим

ОН-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн тайлан	Толилуулгын суурь
ОН-ийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний тайлан	
ОН-ийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	

Дээрх тайлангуудаас Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаас бусад тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан нэгтгэх журам”-ын дагуу Э-тайлан цахим программаар бэлтгэн гаргажээ. Энэ нь төсвийн шууд захирагч нарын жилийн эцсийн санхүүгийн тайланг сумдын Санхүүгийн албаны дарга нар баталгаажуулж, сумдын нэгтгэсэн тайланг төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч хянан баталгаажуулсан байна.

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт

Төсвийн тухай хууль бүрэн хэрэгжиж эхэлснээр төсвийн ерөнхийлөн захирагчдын бүтцэд дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн хяналт аудитын алба нь Монгол улсын засгийн газрын 2014 оны 327-р тогтоол, Аймгийн засаг даргын 2014 оны 11-р сарын 10-ны өдрийн А/577 тоот захирамжаар байгуулагдаж, албаны дарга-1, ахлах байцаагч-1, байцаагч-4 бүгд 6 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Санхүүгийн хяналт аудитын албаны зорилго нь Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй.

Тус алба нь 2017 онд үйл ажиллагааны төлөвлөгөө, хяналт шалгалтын графикаар 9 сумын 63 төсөвт байгууллага болон аймгийн төвийн 36 төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар бүгд 99 байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2 сумын 10 байгууллага, аймгийн төвийн 24 байгууллагад төлөвлөгөөт шалгалт хийж 132.9 сая төгрөгний төлбөр зөрчил илрүүлэн ажилласан байна. Илэрсэн алдаа зөрчлийг хувиар авч үзвэл илүү, дутуу олгогдсон цалин хөлс 28.6 хувь, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 25.5 хувь, үндсэн баримтгүй зарцуулсан 12.1 хувь, ашиглаж дутагдуулсан хөрөнгө 20.9 хувийг тус тус эзэлж байна. Орон нутгийн төсөвт нийт 41.8 сая төгрөгийн орлогыг оруулснаас 14.2 сая төгрөгийг өмнөх оны актын төлбөрийн үлдэгдлээс төвлөрүүлсэн байна. Батлагдсан төлөвлөгөөт шалгалтын 34.3 хувийг хэрэгжүүлэн ажиллаж багаа нь төсвийн хөрөнгийн хүрэлцээ бага, ажиллах хүчний тоо хангалтгүй, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудыг сүүлийн жилүүдэд очиж хяналт тавиагүйгээс олон жилийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх зэргээс хамаарч байна.

Сумдын төрийн сангийн төлөөлөгчид болон аймгийн төрийн сангийн төлөөлөгчид гүйлгээ бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлдэг 1 мэргэжилтэн ажилладаг бөгөөд 2017 онд Нягтлан бодох бүртгэлийн “Тунгалаг бүртгэл” хөтөлбөрийг аймгийн ИТХТ-ийн 2017 оны 47 дугаар тогтоолоор баталж, хөтөлбөрийн хүрээнд 7 хүний бүрэлдэхүүнтэй баг 17 сум, байгууллагын төсвийн 118, ОНӨҮГ 5, ААН-ийн 320 нийт 443 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, заавар зөвлөмж өгч ажиллажээ. Шалгалтаар цалингийн урьдчилгааг ихээр олгож, эргэж суутгадаггүй, эдийн засгийн ангилал зөрчсөн, бэлнээр зарцуулах, анхан шатны баримтгүй, томилолтыг хяналтгүй олгосон, хүүхдийн хоолонд стандарт бус хүнс хэрэглэсэн зэрэгт 31,7 сая төгрөгийг зөрчлийг илрүүлж, арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна.

Хангалтгүй ажиллаж байгаа төсвийн менежер, нягтлан бодогч, нярав 5 хүнийг ажлаас халах, 2 хүнд торгууль, 24 хүнд захиргааны, нийт 31 хүнд хариуцлагын арга хэмжээг тооцуулсан байна. Хөтөлбөрийн хүрээнд бүх сумдаар явж ажиллаж илэрсэн алдааг залруулах зөвлөмж өгөн ажилласан боловч санхүүгийн тайлангийн аудитаар тайланд илэрсэн алдаа зөрчил, хязгаарлалттай, сөрөг дүгнэлтийн тоо нь өмнөх оноос буураагүйгээс үзэхэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангалттай гэж үзэх боломжгүй байна.

Төсвийн тухай хуулиар 2015 оноос эхлэн санхүүгийн алба байгууллагдаж 4 орон тоотойгоор, 1 албаны дарга, төрийн сангийн төлөөлөгч 1, ня-бо 2 ажиллаж байна. Сумуудад байгаа 9-10 байгууллага, төсөл сангийн тайланг 2-3 ня-бо хариуцан ачаалал өнөдөртэй ажиллаж байна. Нөгөө талаас сумын Засаг даргын тамгын газарт байрлаж ажилласнаар байгууллагад тавих дотоод хяналт суларч байна.

Гурав. Шилэн дансны мэдээлэл

Аймгийн ТЭЗ-ийн Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийг үзэхэд сар бүрийн төсвийн гүйцэтгэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ зэргийг зохих түвшинд мэдээлж хэвшсэн бөгөөд Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээний хувьд ихэнх байгууллагууд сар бүрийн санхүүжилтийг орлогын гүйлгээгээр мэдээлж хэвшээгүй, улс, орон нутгийн хөрөнгөөр санхүүжигдэж ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААН-үүд, өөрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч болох хувийн цэцэрлэг, хувийн эмнэлэг, эмийн сангууд Шилэн дансны цахим хуудсанд өөрийн гэсэн цахим хуудасгүй, мэдээллээ байршуулдаггүй зэрэг дутагдал ажиглагдаж байна.

Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагаас 2017 онд хийсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн шалгалтаар Ховд аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 77.1 хувийн биелэлттэй байна гэж дүгнэгджээ. Тус шалгалтаар Шилэн дансны тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн улсын төсөвт 3 байгууллага, орон нутгийн төсөвт 44 байгууллага, ОНӨҮГазрын 2 байгууллага, ТӨҮГазрын 1 байгууллага, нийт 50 байгууллагын төсвийн шууд захирагч нарт хариуцлага тооцуулах албан шаардлагыг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэний дагуу СТСангийн хэлтсээс уг төсвийн шууд захирагчдад хариуцлага тооцож ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд байгууллага бүрийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хянаж холбогдох зөвлөмжийг өгч ажилласан болно.

Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох

ОН-ийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 77493.8 сая төгрөгийг суурь болгон авч түүний 2.0 хувиар тооцон 1549.9 сая төгрөгөөр тогтоов.

Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

ОН-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Аймгийн Ерөнхий нягтлан бодогчийн нэгтгэсэн Е- тайлангаас эксель рүү хөрвүүлж баталгаажуулав.

Төсвийн тухай хуулийн 8.9.5-д төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 01-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасны дагуу дээрх хугацаанд ирүүлсэн болно.

Ховд аймгийн Засаг даргын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 23 тэрбум 450.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 174.2 сая төгрөгийн албан шаардлага, 102.0 сая төгрөгийн залруулга, 21 тэрбум 530.2 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлэв. 102.0 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 23172.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв. Тус зөвлөмжөөс өмнө онуудад хэрэгжүүлсэн дуусаагүй үйлдвэрлэлд бүртгэсэн, хүлээж аваагүй, байгууллагын эзэмшилд байгаа боловч өмчийн албанд бүртгэлтэй 18789.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчлийг албан тоот ирүүлсэн тул материаллаг бус гэж үзлээ. Үүнд:

- ✚ Байгаль хамгаалах сангаас Ховд аймгийн Ерөнхий агнуур зохион байгуулалт хийх, агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлын гэрээг Уламжлалт ав ХХК-тай 9.9 сая төгрөгөөр санхүүжилтын гэрээ байгуулж 70 хувийн урьдчилгаа 6.9 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Уг ажлыг 2017.11.25-нд дуусгаж хүлээлгэн өгөхөөр гэрээний тусгай нөхцөлд заасан боловч хугацаандаа хүлээлгэн өгөөгүй байна. Тайлант онд уг ажил гүйлгээтэй холбоотой 6.9 сая төгрөгийн авлага бүртгээгүй байгаа зөрчил дутагдал нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн **46 дугаар зүйл. Захиалагчийн эрх, үүрэг** 46.1.6.бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих гэсэн заалтуудыг зөрчсөнтэй холбоотойгоор 1.7 сая төгрөгийн төлбөрийн акт бичигдлээ.
- ✚ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчиж, Он дамжсан олон жилийн насжилттай авлага, эзэн холбогдогч нь тодорхой бус, ажлаа хийгээгүй хүлээлгэн өгөөгүй, авлага баталгаажуулаагүй, орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС, улсын төсвийн хөрөнгө оруулалт дансаас 1733.2 сая төгрөгний төлөвлөгдөөгүй зардал гаргасан, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг зөрчин арилжааны банкинд данс нээсэн, хүүгийн орлогыг тайлант тусгаагүй, ЗДТГ-ын нэмэлт дансанд зөвшөөрөлгүйгээр 10.0 сая төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотойгоор **бүгд 1816.1** сая төгрөгийн албан шаардлага бичлээ.

Зургаа. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

6.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

ОН-ийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- ОН-ийн төрийн сангийн дансны үлдэгдэл, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын жижиг мөнгөн сан, харилцах дансдын үлдэгдэл, ОНӨҮГ-ууд, төсөл сангийн төгрөгийн харилцах дансдын үлдэгдэл, замд яваа мөнгөн хөрөнгө,
- Кассад байгаа бэлэн мөнгө.

ОН-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2016 оны эцэст 1525.2 сая төгрөг байснаас 35 хувиар буюу 984.6 сая төгрөгөөр өсөж 2017 оны эцэст 2509.8 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний 1 хувь буюу 25.9 сая төгрөг нь арилжааны банкинд, байршиж байна.

ОН-ийн төсвийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2017 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал: (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс
Кассад байгаа бэлэн мөнгө	8.1	7.7	7.7	-	-
Төгрөг/ЖМС	8.1	7.7	7.7	-	-
Нэмэлт санхүүжилтийн	-	-	-	-	-
Банкинд байгаа бэлэн мөнгө	1,517.1	2,502.1	-	25.9	2,476.20
Төгрөг	1,517.1	2,502.1	-	25.9	2,476.20
Гадаад валют		-	-	-	-
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	1,525.2	2,509.8	7.7	25.9	2,476.20
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:					
Төрийн сан	927.30	1449.2		-	1449.2
Төсөвт байгууллагууд	577.9	1002.5	0.4	5.2	996.9
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	17.5	23.8	5.3	18.6	
Төсөл, сангууд	2.5	34.3	2	2.1	30.1
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	1,525.2	2,509.8	7.7	25.9	2,476.2

Аймгийн хэмжээний мөнгөн хөрөнгийн 2017 оны эцсийн үлдэгдэл 2509.8 сая төгрөгний 57.8 хувь буюу 1449.2 сая төгрөг төрийн сангийн, 39.9 хувь буюу 1002.5 сая төгрөг төсөвт байгууллагуудын, 1 хувь буюу 23.8 сая төгрөг Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын, 1.3 хувь буюу 34.3 сая төгрөг нь төсөл сангуудын мөнгөн хөрөнгө эзлэж байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 98.7 хувь буюу 2476.2 сая төгрөг төрийн сангийн нэгдсэн дансанд, 1 хувь буюу 25.9 сая төгрөг арилжааны банкинд, 0.3 хувь байгууллагын кассанд байршиж байна.

6.2 Мөнгөн хөрөнгө дансанд илэрсэн алдаа зөрчилүүд:

- ✚ ОН-ын төсвийн байгууллагуудын дүнгээр санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалт, баталгаажуулалт, санхүүгийн сахилга, хариуцлагатай холбоотой Төсвийн тухай хуулийн 6.4.1, 6.4.8, НББ-ийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6 дахь заалт, ХХОАТ-ын тухай хуулийн 8.1.2, Төрийн албаны тухай хуулийн 26.6 дахь заалт, УИХ-н 2016 оны 47 тоот тогтоол, 2017 оны 67 тоот тогтоолуудыг зөрчин нийт 49 актын 90.1 сая төгрөгний төлбөрийн акт тогтоосон байна.
- ✚ Жаргалант сумын хүүхдийн цэцэрлэгүүдэд зах зээлийн үнээс өндөр үнээр хүнсний материал нийлүүлсэн, Дарви сумын ЗДТГ нь шатахууны тооцоо бодоогүй, ОНХС-гийн өмнөх оны авлагыг барагдуулан ажиллаагүй, тайлант оны хөрөнгө оруулалтын ажлуудыг данс бүртгэлд тусгаагүй, төсвийн захирагч нарын буруу гаргасан шийдвэрээс шалтгаалан шүүхийн шийдвэрээр төсвөөс цалингийн зардал гаргасан, анхан шатны баримтгүй, тамга тэмдэггүй, гарын үсэггүй баримтаар гүйлгээ хийсэн, ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажлын гүйцэтгэлд хэрэгжүүлээгүй, комисс хүлээн аваагүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, ОНХС-гийн мөнгийг бэлнээр олгож ашгийн татвар суутгаагүй, төсөл арга хэмжээний мөнгийг олгоод авлагаар бүртгээгүй, урсгал зардалд бүртгэсэн, төрийн албан хаагчид гадаад аялуулсан, боловсролын салбарын байгууллагууд цалингийн үр дүнгийн урамшуулалыг олгохдоо холбогдох заавар журмыг мөрдөхгүйгээр хавтгайруулан олгосон, тушаал шийдвэргүйгээр төсвийн хөрөнгийг зарцуулсан, бэлэг дурсгал, ирсэн төрийн албан хаагчдын хоолны зардлыг төсвөөс санхүүжүүлсэн автомашинд сэлбэг, засварын зардалд норм хэмжээнээс илүү

зарцуулсан зэргээр 39 албан шаардлагаар 1126.0 сая төгрөгний зөрчил арилгуулах хугацаатай үүрэг өгөгдсөн байна.

- ✚ Мянгад, Ховд, Цэцэг, Дөргөн сумдад олгогдсон 17.5 сая төгрөгийн гамшгийн мөнгөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан нь Гамшгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.11-д “хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.
- ✚ Дарви суманд арилжааны банкинд зөвшөөрөлгүйгээр данс нээж орлого бүрдүүлэн зарцуулсан ч дансанд жилийн эцсийн тайлангаар хэдэн төгрөгний үлдэгдэлтэй байгаа нь мэдэгдэхгүй байгаа тул Төсвийн тухай хуулийн 35.5-д “Банкинд төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур нээсэн төсвийн байгууллагын дансанд тухайн шатны төрийн сан болон төрийн аудитын байгууллага үзлэг, хяналт хийн, энэ хуулийн 35.3-т заасан зөвшөөрөлгүйгээр нээсэн дансыг хаалгах, хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд татан төвлөрүүлнэ” гэсэн заалтын дагуу Дарви сумын ХААН банкинд нээсэн байгаль хамгаалах сангийн дансыг хааж үлдэгдлийг төрийн санд төвлөрүүлэх албан шаардлага өгөх.
- ✚ Орон нутгийн ерөнхий орлогоос Мянгад сумын ЗДТГ-ын нэмэлт дансруу эрхийн актгүйгээр 5.0 сая төгрөгийг шилжүүлж ЗДТГ, ИТХ-ын НДШ, ХХОАТ, бараа материалын өглөгийн төлсөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Долоо. Авлагын бүртгэл, тайлагнал

7.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Ховд аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 7056.3 сая төгрөг байснаас тайлант онд 2811.1 сая төгрөгөөр нэмэгдэж 2545,8 сая төгрөгөөр буурч оны эцэст 265,2 сая төгрөг буюу 28.8 хувиар 7321.5 сая төгрөгөөр тайлагнагдсан байна. Ажилчидтай холбогдсон авлага 14.2 сая төгрөгөөр буурч байгууллагаас авах авлага 445.6 сая төгрөгөөр өсч хүмүүсээс авах авлага 83.0 сая төгрөгөөр буурч зээлийн авлага

Нэр төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
33100 Ажиллагчидтай холц	91.4	126.3	140.6	77.2
33200 Төлбөртэй үйлчилгэ	98.3	27.7	45.6	80.4
33300 Татаас, санхүүжилти	3.6	11.0	3.7	11.0
33400 Зээлийн хүүгийн авл	53.4	37.5	40.5	50.5
33401 Дансны авлага /ТӨҮИ	301.7	19.5	32.4	288.6
33402 Татвар, НДШ-ын авл	2.3	1.5	3.8	0.0
33510 Байгууллагаас авах	1,604.9	1,633.8	1,188.2	2,050.5
33520 Хувь хүмүүсээс авах	243.5	66.2	149.0	160.7
33600 Зээлийн авлага	4,657.2	887.6	942.1	4,602.7

Байгууллага	Эхний үлдэгдэл	Тайлант он	Өсөл	Нийт дүн
Алтай-1601 Total	223.4	233.5		
Булган-1602 Total	557.2	525.4	31.8	12%
Буянт-1603 Total	331.2	264.9	66.2	15%
Дарви-1604 Total	224.6	207.8	16.7	8%
Дөргөн-1608 Total	229.6	241.8	(11.7)	6%
Дуут-1605 Total	218.9	208.7	10.0	5%
Жаргалант-1617 Total	1,615.7	1,266.5	349.0	22%
Зэрэг-1606 Total	229.7	228.6	1.1	3%
Манхан-1607 Total	120.5	193.3	(72.8)	17%
Мөнххайрхан-1611 To	193.4	175.7	17.5	6%
Мөст-1618 Total	228.8	235.8	(7.0)	3%
Мянгад-1609 Total	245.8	235.7	10.1	7%
Үенч-1612 Total	314.2	217.5	96.7	15%
Ховд сум-1613 Total	210.7	199.5	11.4	6%
Ховд шууд-1600 Total	1,347.9	2,129.1	(781.1)	45%
Цэцэг-1619 Total	195.3	194.8	0.5	1%
Чандмана-1615 Total	397.7	399.7	(2.0)	2%
Эрдэнэбүрэн-1616 To	171.7	163.3	8.4	4%
	7,056.3	7,321.6	(265.2)	

буураагүй байна. Урьдчилж гарсан зардлын авлага оны эхний үлдэгдэл 1850.1 сая төгрөг байснаас 120,1 сая төгрөгөөр буурч оны эцэст 1730,7 сая төгрөгөөр тайлагнаж урьдчилгаа тооцооны зардлын авлага төдийлөн буураагүй цалин, томилолтын урьдчилгаа 4,3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Авлагыг сум тус бүрээр хүснэгтээр харуулбал:

Дээрх хүснэгтээс үзэхэд аймгийн нийт авлага 12.8 хувь буюу 265.2 сая төгрөгөөр зарим байгууллагын авлага өссөн байна. Өсөлт, бууралтыг сум бүрээр авч үзвэл Манхан сум 72.8 сая төгрөгөөр, Дөргөн сум 11.7 сая төгрөгөөр, Мөст 7.0 сая төгрөгөөр, Чандмань сум 2,0 сая төгрөгөөр. аймгийн байгууллагууд 781.1 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт авлагын 4602.6 сая төгрөгийг СХСангийн авлага, 1034,1 сая төгрөг нь ОНХСангийн авлага, хөрөнгө оруулалтын авлага 422,1 сая төгрөг, төсөвт байгууллага 685,7 сая төгрөг, ОНӨҮГ-ын 271,2 сая төгрөг, бусад авлага 1280,8 сая төгрөгийн авлага барагдаагүй байгаа нь авлага тодорхой хэмжээгээр буурахгүй байгаад нөлөөлсөн байна.Нийт авлагыг графикаар харуулбал:

Нийт авлагын дийлэнх хувийг СХСангийн авлага эзэлж байгаа боловч аймаг хөгжүүлэх сангийн авлага 119.1 сая төгрөг, аймгийн хөрөнгө оруулалтын авлага 422.1 сая төгрөг, УТХО-ын авлага 450.2 сая төгрөг, Хөшөөт хөгжил сангийн авлага 684.5 сая төгрөгийн авлага буурахгүй байсаар байна.



Аймгийн төсөвт болон ОН-ийн өмчит аж ахуйн нэгж, сумдын байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлагын данстай холбоотой илэрсэн алдаа зөрчлүүд болон авлагын задаргааг данс бүрийн хариуцагчаар ангилбал дараах байдалтай байна. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн авлага: Санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн хөгжлийн сангийн авлага 5 суманд 350,3 сая төгрөг аймагт 1034.1 сая төгрөг нийт 1384.4 сая төгрөгийн авлага үлдэгдэлтэй тайлагнасан байгаа нь тендер, төсөл, гэрээгээр шалгарсан аж ахуйн нэгж байгууллагууд ажлаа дутуу хийсэн, хүлээлгэж өгөөгүй, огт хийгээгүй зэрэг гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй авлага нэмэгдсэн байна. Тухайлбал: Жаргалант суманд 244.8 сая төгрөгийн авлага байгаагаас Иргэн Б.Лхагвацэрэн Алагтолгой багийн гэрэлтүүлэгийн ажил 23.1 сая төгрөг, иргэн Л.Мягмар Баатархайрхан багийн гэрэлтүүлэгийн ажил 12,5 сая төгрөг, иргэн Б.Аюурзана Тахилт багийн тоглоомын талбай 10,0 сая төгрөг, Эко Ховд ХХК Жаргалант сумын хүндэт тэмдэг 30.0 сая төгрөг, Гулзатын шил ХХК Наран, Рашаант багийн гэрэлтүүлэг 25.6 сая төгрөг, Эвлэл ХХК Мандах наран хорооллын бүсэд инженерийн худаг барих 29.1 сая төгрөг, Ирмүүн аргамаг ХХК Мандах наран хорооллын агаарын цахилгаан дамжуулах шугам 136.5 сая төгрөг, Ховд өнөр бүл ХХК орон сууцны ундны усны аюулгүй байдлыг хангах 18.0 сая төгрөг, Шинэ төгс шийдэл ХХК залуучуудын соёл амралтын хүрээлэнгийн тохижилт хийх 17.1 сая төгрөгийн авлага тус тус байна.

Аймгийн ОНХС-гийн авлага 1034.1 сая төгрөг байгаагаас Долчим ХХК нөөцийн мах бэлтгэх 70.0 сая төгрөг, Жишиг хашаа барих 100.0 сая төгрөг, Алтайн буйлааст ХХК-аас 14.5 сая төгрөг, БИСЭТ ХХК-аас 20.0 сая төгрөг, Нөөцийн мах бэлтгэх 15.0 сая төгрөг, ХХААГазраас өвсний үнэ 35.2 сая төгрөг гэх мэт 16 аж нэгж компануудтай холбоотой ажил дутуу хийгдсэн, хийсэн ажлаа хүлээлгэн өгөөгүй, хугацаандаа хийгээгүй, огт ажлаа эхлээгүй зэрэг авлагууд байна. 2017 онд Хотын хөгжлийн санд 5.0 сая төгрөг, мах нөөцлөх, жишиг хашаа барих, хүүхэд хөгжлийн төв барих 274.4 сая төгрөгтэй холбоотой авлагуудыг барагдуулах талаар тухайн албан газрууд руу албан тоот илгээж шаардаж байгаа боловч үр дүнгээ өгөхгүй байсаар байгаа тул хуулийн байгууллагад шилжүүлж барагдуулах шаардлагатай байна. Зураг төсөв нь урьдчилж

хийгдсэн 754.7 сая төгрөгийн зураг төсвийн авлага нь ажлын санхүүжилт батлагдаагүй гэсэн шалтгаанаар хүлээгдэж байна.

Сум хөгжүүлэх сангийн авлага: Санхүүгийн тайлангийн аудитаар сум хөгжүүлэх сангийн 4602.6 сая төгрөгийн авлага нь зорилтот бүлэгт чиглэсэн, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжсэн эргэн төлөгдөх нөхцөлтэй авлага байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн хэрэгжилтийг тухай бүр тооцоо хийн хянаж, баталгаажуулж байгаа боловч зарим сумдын зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн, хугацаа хэтэрсэн зээлийн алданги тооцож авлагад тусгаагүй, суутгаж аваагүй, зориулалт бусаар ашиглаж байгаа, тооцоо нийлсэн актаар баримтжуулж баталгаажуулаагүй зэрэг 2168,6 сая төгрөгийн зөрчил дутагдлууд байсаар байна.

Аймгийн хөрөнгө оруулалтийн авлага: Санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгө оруулалтийн дансны 395.3 сая төгрөгийн авлага нь урьд онуудаас дамжиж ирсэн Баруун монгол интернейшнел ХХК халил аргаар махан зоорь байгуулах авлагын үлдэгдэл 226.2 сая төгрөгийн авлагын тооцоог 2015 оны 09-р сарын 01-ны 115 тоот ИТХ-ын тогтоолоор тус компаний Хан Алтайн дуулал цогцолбор барьж байгуулсан байгууламжийг хүлээн авч тооцоо хийх шийдвэр гарсан боловч одоог хүртэл хэргжүүлээгүй байгааг анхаарч цаашид дээрхи цогцолборыг хүлээн авч авлагыг тооцоог барагдуулах, Алтайн буйлааст ХХК Зэрэг суманд хүүхэд хөгжлийн төв барих 100.0 сая төгрөг, ББМЗЗТ ХХК Мөнххайрхан нутгийн удирдлагын ордон 30.3 сая төгрөг, Модерн пропертиз ХХК зураг төсвийн 52.6 сая төгрөг, эзэн холбогдогч нь тодорхойгүй 12.7 сая төгрөгийн ажил дутуу хийгдсэн, хийсэн ажлаа хүлээлгэн өгөөгүй, хугацаандаа хийгээгүй, хүлээлгэн өгсөн боловч санхүүжилт нь тодорхой бус авлага бүртгэлтэй байна. Эдгээр авлагуудыг барагдуулах талаар ИТХ болон хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын авлага: Санхүүгийн тайлангийн аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын дансны 450.2 сая төгрөгийн авлага нь 2013 онд БИСЕТ ХХК-нь 160.0 сая төгрөгийг Мөст суманд хүүхдийн цэцэрлэг барих ажлын урьдчилгаа төлбөр болгон аваад одоог хүртэл хүлээгдэж байгаа авлагад тусгагдсан байна. Энэ нь УТХОруулалтаас санхүүжилт орж ирээгүй гэсэн тайлбар өгч байна. Мөн хууль хяналтийн байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Аймаг хөгжүүлэх сангийн авлага: Санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн өмчийн сан дансанд 119.1 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа боловч өмчийн сангийн тайланд 46.8 сая төгрөгийг авлага хүлээн зөвшөөрч тусгагдсан байна. Оны эхэнд 71.6 сая төгрөгийн авлага аймгийн санхүүгийн нэгдсэн тайланд тусгагдсан боловч өмчийн сангийн санхүүгийн тайланд тусгагдаагүй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй буцаан төлөгдсөн эсэх нь мэдэгдэхгүй авлага байсанаас Оож Ван ХХК –ны 17.1 сая төгрөгийн авлагыг машин хөрөнгөд авсан гэж хасаж 0.9 сая төгрөгийн авлага бүртгэсэн байна. Лут-Очир ХХК 20.1 сая төгрөг, Эрдэнэ-Өлзий ХХК 6.7 сая төгрөг, Цементийн үйлдвэр 8.8 сая төгрөг, Эзэн холбогдогч нь тодорхой бус 17.5 сая төгрөгийн авлага он дамжин удааширч байгааг холбогдох газарт санал хүргүүлж шийдвэрлүүлэх шаардлагатай байна. Мөн он дамжсан 8 жил болж байгаа Оюу мандал ХХК -ны захирал Д.Басбиштэй холбоотой газрын дуудлага худалдааны 30% болох 23.5 сая төгрөг одоо хүртэл барагдаагүй байгаа нь авлагын үр өгөөжийг бууруулж ИТХ-ын тогтоол, хууль дүрэм, журам хэрэгжихгүй хувь хүнд ашигтайгаар эргэх нөхцөл бүрдсэн байгаад цаашид анхаарах хэрэгтэй.

Хөшөөт хөгжлийн сангийн авлага: Санхүүгийн тайлангийн аудитаар хөшөөт хөгжлийн сангийн 93.9 сая төгрөгийн авлага оны эхэнд байснаас 1256.2 сая төгрөгөөр нэмэгдэж 665.6 сая төгрөгийн авлага барагдаж оны эцэст 684.5 сая төгрөг санхүүгийн тайланд тусгагдсан байна.

Ангилалдаагүй зардлын авлага: Санхүүгийн тайлангийн аудитаар хотын хөгжлийн төлөө сангийн данснаас 2015 онд 22.5 сая төгрөгийн зарлага гарч 2016 онд 3.0 сая төгрөгөөр буурч 19.2 төгрөгийн үлдэгдэлтэй одоог хүртэл барагдаагүй байна.

7.2 Аймгийн ТЕЗ-дын авлагын талаар

Аймгийн төсөвт болон ОН-ийн өмчит аж ахуйн нэгж, сумдын байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлагын данстай холбоотой нийт 6101.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнээс он дамжсан олон жилийн насжилттай авлага 3190.0 сая төгрөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй 2793.7 сая төгрөг, авлагыг зөрүүтэй тайлагнасан 118.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасан “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Нэрс	Насжилт өндөртэй авлага	Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	Залруулга хийлгэсэн авлагын дүн
Алтай	128.8	53.6	
Булган	203.3	127.1	0.9
Буюнт	76.8	47.9	5.4
Дарви	70.2	43.8	
Дуут	71.9	44.9	
Зэрэг	82.6	33.9	
Манхан	35.1	35.1	
Дөргөн	92.5	57.8	
Мянгад	117.5	37.7	5.4
Мөст	93.2	69.9	
Мөнххайрхан	71.9	20.6	
Төв	112.5	80.4	17.5
Ховд	78.1	97.6	1.6
Цэцэг	62.5	78.2	54.3
Чандмана	151.2	94.5	
Эрдэнэбирэн	26.3	26.3	
Жаргалант	686.4	245.1	24.5
Ховд Аймаг	1,029.2	1599.3	8.5
Нийт дүн	3,190.0	2,793.7	118.1

Цаашид аймгийн нийт авлагын дүнд шинжилгээ хийж үр өгөөжийг тодорхойлж авлагаа баталгаажуулж баримтжуулах, он дамжин төлөгдөхгүй байгаа авлагыг хуулийн байгууллагад шилжүүлж барагдуулах шаардлага тулгарч байна.

ОНХсангаас хийгдсэн зураг төсвийн зардлын зарим ажлууд хийгдсэн боловч урьдчилж олгосон зураг төсвийн мөнгөө суутгаж аваагүй эрсдэл байгааг анхаарч дахин бүх байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулан баримтжуулах шаардлагатай байна.

Найм.Бараа материалын бүртгэл, тайлагнал

8.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар :

ОН-ийн төсвийн ерөнхийлөн захирагчдын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эхний үлдэгдэл 3937.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4203.0 сая төгрөгөөр тайлагнагдаж, тайланд онд 265.3 сая төгрөгөөр өссөн байна.

(сая.төгрөгөөр)

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
Тусгай зориулалтын материал	377.5	408.2	30.7	0,9
Эм боох материал	134	89.9	-44.1	-1.4
Дуусаагүй үйлдвэрлэл	0	0	0	0

Бэлэн бүтээгдэхүүн	73	81.3	8.3	0.8
Бичиг хэргийн материал	101.4	99.5	-1.9	-1
Аж ахуйн материал	871.6	949.7	78.1	0.9
Сэлбэг хэрэгсэл	60.3	93.6	33.3	1.5
Түлш шатхуун, тослох материал	177.6	201.1	23.5	1.1
Барилга засварын материал	19.7	24.3	4.6	1.2
Хүнсний материал	272.7	251.9	-20.8	-0.9
Бусад хангамжийн материал	1575.5	1731	155.5	1
Мал амьтад	273.8	271.9	-1.9	-1
Нөөцийн бараа	0	0	0	0
НИЙТ ДҮН	3937.6	4203	265.3	100

Бараа материалын өсөлтийг нэр төрлөөр нь авч үзвэл бэлэн бүтээгдэхүүн 8.3 сая, аж ахуйн материал 78.1 сая, сэлбэг хэрэгсэл 33.3 сая, барилга засварын материал 4.6 сая, тусгай зориулалтын материал 30.7 сая, түлш шатах тослох материал 23.5 бусад хангамжийн материал 155.5 сая төгрөгөөр өссөн бол эм боох материал 44.1 сая, бичиг хэргийн материал 1.9 сая, мал амьтад 1.9 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант онд нийт бараа материалын данс 6390.7 сая төгрөгөөр нэмэгдсэнээс төсвийн болон өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 6143.4 сая төгрөгийн, хандив тусламжаар 199.9 сая төгрөгийн, шилжүүлж авсан 15.8 сая төгрөгийн бараа материал байгаа бол бусад хэлбэрээр 31.5 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна.

Тайлант онд нийт бараа материалын дүн 6125.4 сая төгрөгөөр буурснаас 5972.5 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан буюу худалдсан, 40.4 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн /зарим нь бүтцийн өөрчлөлттэй холбоотой/, бусад байдлаар 112.3 сая төгрөгөөр бараа материалын данс буурсан байна.

8.2 ОН-ын ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар бараа материалтай холбоотой гарсан зөрчлийн талаар

Аудитаар бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, данс бүртгэлд орлого авалгүй шууд зардалд бүртгэсэн, бараа материалын хөдөлгөөний тайлан гаргаагүй, бараа материалыг анхан шатны баримтгүй зарцуулсан, тооллогод хамруулаагүй, үнийн жишгээс өндөр дүнгээр бараа материал бэлтгэсэн, норм нормативаас илүү хүнсний материал зарлагдсан, бараа материалын тооцоо бодож актаар баталгаажуулаагүй зэрэг нийт 547.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Тухайлбал:

- ✚ Манхан сумын ерөнхий боловсролын сургууль хүүхдийн хоолны хүнсний материал дутуу нийлүүлсэн 2.1 сая, Манхан сумын цэцэрлэг 0.6 сая, Жаргалант сумын 8-р цэцэрлэг 0.4 сая, Жаргалант сумын 3-р цэцэрлэг 2.0 сая, Буянт сумын ерөнхий боловсролын дунд сургууль 0.5 сая төгрөгийн хэрэгцээ шаардлага хангахгүй хүнсний бүтээгдэхүүн нийлүүлсэн,
- ✚ Жаргалант сумын 15 дугаар цэцэрлэг, Жаргалант сумын 13 дугаар цэцэрлэг, Ховд асрамжийн газар, Буянт сумын хүүхдийн цэцэрлэг, Ховд аймгийн жаргалант сумын 2-р цэцэрлэг, Ховд аймгийн жаргалант сумын 9-р цэцэрлэг, Ховд аймгийн жаргалант сумын 6-р цэцэрлэг, Ховд аймгийн жаргалант сумын 5-р цэцэрлэг, Жаргалант сумын 12 дугаар цэцэрлэг хүнсний зарим бүтээгдэхүүнийг аймгийн Төрийн сангаас сар бүр гаргаж байгаа зах зээлийн жишиг үнээс өндөр үнээр хүнсний болон аж ахуйн материал нийлүүлсэн,
- ✚ Ховд аймгийн Үенч сумын Засаг дарга, Мянгад сумын засаг даргын тамгын газар бараа материалын тайлан иж бүрэн биш,
- ✚ Чандмань сумын хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, Үенч сумын ерөнхий боловсролын сургууль, Мөст сумын хүүхдийн цэцэрлэг, Мөст

сумын ерөнхий боловсролын сургууль, Жаргалант сумын 11-р цэцэрлэгүүд хоолны талон баталгаажуулаагүй хоол хүнс зарлагдсан зэрэг алдаа зөрчил илэрч нийт 147.1 сая төгрөгийн 18 албан шаардлага бичигдсэн байна.

Ес. Үндсэн хөрөнгийн талаар

9.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар

Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагнал


ОН-ын ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө 2017 оны эхэнд 184,6 тэрбум төгрөгний хөрөнгөтэй, тайлант онд 10,8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 2017 оны эцэст 195,5 тэрбум төгрөгний үлдэгдэлтэй байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	зөрүү дүн
Барилга байгууламж	124,982.7	130,187.6	5,205.0
Тээврийн хэрэгсэл	4,610.2	5,008.5	398.3
Машин тоног төхөөрөмж	14,301.0	15,116.6	815.6
Тавилга эд хогшил	6,201.7	6,497.0	295.4
Зам гүүрийн байгууламж	13,961.0	14,002.2	41.2
Батлан хамгаалах тоног төхөөрөмж	2.6	2.6	0.0
Түүх соёлын дурсгалт зүйл	1,283.6	1,290.8	7.2
Дуусаагүй байгууламж	11,470.9	13,660.7	2,189.9
Номын фонд	1,139.0	1,250.1	111.1
Бусад үндсэн хөрөнгө	6,493.6	8,308.2	1,814.6
Программ хангамж	161.0	163.1	2.1
Биет бус хөрөнгө	29.5	29.8	0.3
Бусад хөрөнгө	0.0	3.0	3.0
	184,636.5	195,520.1	10,883.6

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 13175.78 сая төгрөгөөр /үүний дотор худалдан авсан 634.44 сая, хандив тусламжаар 3263.78 сая, шилжүүлж авсан 374.48 сая, бүтцийн өөрчлөлтөөр 762.06 сая, бусад 8141.02 сая бүгд 13175.78 сая/ нэмэгдэж, 2292.18 сая төгрөгөөр /үүний дотор акталсан 698.48 сая, худалдсан 55.35 сая, шилжүүлсэн 688.17 сая, бүтцийн өөрчлөлтөөр 759.72 сая, бусад 88.46 сая, дахин үнэлгээний хорогдол 2.0 сая бүгд 2292.18 сая/ хасагдаж, тайлант онд 8112.94 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна

Үндсэн хөрөнгийн бүтцийг диаграммаар харуулбал:



Нийт үндсэн хөрөнгийн 66,58 хувийг барилга байгууламж, 3,32 хувийг тавилга, эд хогшил, 7,73 хувийг машин тоног төхөөрөмж, 6,98 хувийг дуусаагүй барилга байгууламж, 2,56 хувийг тээврийн хэрэгсэл, 4,25 хувийг бусад үндсэн хөрөнгө, 1,42 хувийг биет бус болон бусад хөрөнгө тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчлийн талаар

ТЕЗ-ийн 2017 оны нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✚ Аудитаар Цэргийн штабын дайчилгааны офицерт суурин компьютер, 3-н үйлдэлт принтер, ханын төмөр шкаф зэргийг 2,5 сая төгрөгөөр худалдан авсаныг бүртгэл тайланд тусгаагүй, Хүнс хөдөө аж ахуйн яамнаас 42.5 сая төгрөгийн өртөг бүхий 17 мотоциклийг сумдын мал эмнэлэгийн үржлийн албанд хуваарилсаныг сумдын ЗДТГазрын данс бүртгэлд тусгаагүй байна
- ✚ Мянган угалзат ОНӨААТҮГазрын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа Ахуйн үйлчилгээний төвийн барилгын 847.4 сая төгрөг, Хүүхдийн паркийн барилга байгууламжийн 5810.9 сая төгрөг, Авто тээврийн үндсэний төвийн ховд аймаг дах салбарын ашиглаж байгаа Хот хоорондын тээвэр зохицуулах байрны 35.0 төгрөг, Авто зогсоолын хашааны 5.7 сая төгрөг, Соронзон нет ХХК-ийн 143.5 сая төгрөг, **нийт 6842.6** сая төгрөгийн хөрөнгүүд нь тухайн байгууллагуудынхаа хөрөнгөнд бүртгэгдэлгүй аймгийн Орон нутгийн өмчийн газрын данс бүртгэлд тусгагдсан байна. Энэ нь УСНББОУС-ын 17 дугаар стандарттай нийцэхгүй байна.
- ✚ Ажлаа дуусгасан ч улсын комисс хүлээн аваагүй тул хөрөнгөнд бүртгэх шийдвэр гараагүй, нэмэлт ажлаа гүйцэтгээгүй, ажлаа хангалтгүй гүйцэтгэсэн гэх шалтаануудын улмаас үндсэн хөрөнгөнд бүртгэж аваагүй байна. Тухайлбал: Рашаант өрхийн эмнэлэгийн 221.2 сая төгрөг, Баатархайрхан өрхийн эмнэлэгийн 330.0 сая төгрөг, Үенч сумын хүүхдийн цэцэрлэгийн 250.0 сая төгрөг, Жаргалант сумын төв талбайн засвар, Засмал зам, Ногоон байгууламжийн нийт 4499.6 сая төгрөг, Дуут сумын нутгийн удирдлагын ордонгийн 733.7 сая төгрөг, Мөнххайрхан сумын нутгийн удирдлагын ордонгийн 614.6 сая төгрөг, Чандмань сумын хашаа граж хогийн цэг, Ногоон байгууламж, цементэн зам, явган хүний зам, мал нядалгааны цэг, Сүлжээ багийн төв, халуун усны нийт 557.9 сая төгрөг, Дөргөн сумын засмал замын 34.3 сая төгрөг, Шимус ОНӨААТҮГазрын цэвэрлэх байгууламж, өргөтгөлийн станцын нийт 3485,0 сая төгрөг, Буянт сумын услалтын системийн 1211.8 сая төгрөг, Зэрэг сумын соёлын төвийн хашаа, гадна талбайн 8.0 сая төгрөг, **нийт 11946.3** сая төгрөгийн барилга, байгууламжийг бүртгэл тайланд тусгаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, талагналтын журмын 6.1-д “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусах хүртэл, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч байгууллага эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана. Их засварын зардлыг захиалагч байгууллага нь хөрөнгийн дүн, засварын төрлөөр тодруулга тайланд тусгана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тайлант онд шинээр байгуулагдсан байгууллага, ААН-үүдийн орон нутгаас үйл ажиллагаандаа ашиглаж байгаа хөрөнгийг тус байгууллагын үндсэн хөрөнгөнд шилжүүлж бүртгээгүй, тайлант онд шинээр худалдан авсан хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчил илэрлээ. Тухайлбал:

- ✚ Булган сумын 2-р цэцэрлэг нь тайлант онд шинээр ашиглалтанд орсон цэцэрлэгийн барилгыг 1365.9 сая төгрөгөөр, тоног төхөөрөмжийг 8.8 сая төгрөгөөр, тавилга хэрэгсэлийг 19.5 сая төгрөгөөр **нийт 1394.2** сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч данс бүртгэлдээ тусгасаныг ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-т “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.
- ✚ Мянгад Шим-ус ОНӨААТҮГазар нь эхлэлтийн тайланд 494.2 сая төгрөгийн хөрөнгийг Улсын бүртгэлийн хэлтэст бүртгүүлсэн ч ЗДТГ-ын бүртгэлээс шилжүүлэх шийдвэр гараагүйтэй холбоотой байгууллагын дансанд уг хөрөнгийг бүртгээгүй, мөн тайлант хугацаанд үйл ажиллагааны орлогоос 0.5 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан ч данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-т “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.
- ✚ Тээлийн илч ОНӨААТҮГазар нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан сумын дулааны нэгдсэн шугам сүлжээг түшиглэн үйл ажиллагаагаа явуулж байгаа ч хөрөнгө оруулалтын ажлыг улсын комисс хүлээн аваагүйтэй холбоотой тус шугам сүлжээг бүртгэл тайланд тусгаагүй байна. Байгууллагын бүртгэлд 3,0 сая төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэн ч тайланд онд элэгдлийн зардал тооцоогүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 4.1.1-д “Аж ахуй нэгж байгууллага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Арав.Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

10.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар

Орон нутгийн ТЕЗ-дын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл **849.7** сая төгрөг байснаас тайланд онд 145.5 сая төгрөгөөр буурч, оны эцэст **704.2** сая төгрөгт хүрсэн байна.

Урт хугацаат өр төлбөр оны эцэст 943.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэр төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
41310 Ажилчидтай холбогдсон	84.6	6,400.0	6,419.8	64.8
41320 Бараа үйлчилгээний зар	42.3	996.4	1,011.1	20.5
41430 Барьцаа, дэнчингийн ур	1.6	1.1	1.1	1.7
41330 Татаас, санхүүжилт, шил	18.3	296.3	196.4	118.1
41361 Байгууллагад төлөх өглө	123.5	6,156.6	6,169.8	117.4
41362 Хувь хүмүүст төлөх өглө	37.9	651.5	665.4	23.9
41363 Татварын өглөг /ТӨҮГ/	159.0	113.1	226.7	45.5
41364 НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	12.7	205.9	195.0	23.5
41366 Дансны өглөг /ТӨҮГ/	369.9	84.5	165.5	288.8
Нийт дүн	849.8	14,905.4	15,050.8	704.3

Нийт өр, төлбөрийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

/сая төгрөг/

Тайлант хугацааны эцэст нийт өр төлбөрийн 64.8 хувийг ажилчидтай холбогдсон өглөг, 23.3 хувийг хүмүүст өгөх өглөг, 45.5 хувийг татварын өглөг, 25,6 хувийг байгууллагад өгөх өглөг, 9,3 хувийг хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг, 12,7 хувийг дансны өглөг, бусад өглөг 18 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгтээс үзэхэд тайлант оны эцэст нийт өр төлбөрийн 55.3 хувийг аймгийн төвийн байгууллагууд 45 хувийг сумын төсөвт байгууллагууд эзэлж байгаагаас Алтай сум 20.2 сая төгрөг, Жаргалант сум 45.7 сая төгрөг, Зэрэг сум 6.5 сая төгрөгөөр өсч Чандань сум 16.4 сая төгрөг, Үенч сумын 48.3 сая төгрөгийн өр буураагүй Булган сум 39.9 сая төгрөгөөр Дөргөн сум 20.5 сая төгрөгөөр Мөст сум 5.4 сая төгрөгөөр, Мөнххайрхан сум 6.6 сая төгрөгөөр, буурсан байна.

Нийт өр төлбөрийн 42.4 хувийг Ховд аймгийн өглөг эзэлж байгаа бөгөөд Амгийн ТЕЗ-ын 13.6 хувь буюу 59.1 сая төгрөгийг ОНХСангийн өглөг, 65 хувь буюу

288.9 сая төгрөгийг ОН-ийн өмчит үйлдвэрийн газрууд, 9.2 хувь буюу 226.9 сая төгрөгийг төсөвт байгууллагуудын өр эзэлж байна. 2017 оны санхүүгийн тайлангаар өр төлбөр буурсан үзүүлэлттэй байгаа нь өрийн үр өгөөжийг дээшлүүлж ажилласан байна. Өр төлбөр өссөн, буурсан үзүүлэлтийг авч үзэхэд:

Байгууллага	Эхний үлдэгдэ	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэ
Алтай-1601 Total	2.2	1,170.4	1,152.3	20.2
Булган-1602 Total	54.8	1,731.2	1,771.4	14.7
Буянт-1603 Total	13.8	0.6	13.8	0.6
Дарви-1604 Total	13.0	110.3	114.1	9.2
Дөргөн-1608 Total	21.7	1.2	21.7	1.2
Дуут-1605 Total	25.7	10.1	23.2	12.6
Жаргалант-1617 Total	13.3	4,690.3	4,657.8	45.7
Зэрэг-1606 Total	3.4	24.0	17.6	9.8
Манхан-1607 Total	5.5	1,913.0	1,917.3	1.2
Мөнххайрхан-1611 Total	6.8	0.2	6.8	0.2
Мөст-1618 Total	8.6	3.2	7.9	3.9
Мянгад-1609 Total	20.9	71.8	79.3	13.4
Үенч-1612 Total	46.8	10.0	8.5	48.3
Ховд сум-1613 Total	4.5	2.0	3.4	3.1
Ховд шууд-1600 Total	586.5	4,991.6	5,084.0	494.1
Цэцэг-1619 Total	4.8	126.2	121.4	9.7
Чандмана-1615 Total	16.3	4.5	4.5	16.4
Эрдэнэбүрэн-1616 Total	1.1	44.7	45.7	0.1
Нийт дүн	849.8	14,905.4	15,050.9	704.3

- ✚ Аймгийн аж ахуйн нэгж байгууллагуудын орон нутгийн болон улсад төлөх татварын орлогын өглөг 27.5 сая төгрөгөөр, НДШ-ийн өглөг 11.7 сая төгрөгөөр, татаас санхүүжилтийн өр 118.4 сая төгрөгөөр, дансны өглөг 288.8 сая төгрөгөөр өсч бусад өр 117.1 сая төгрөгөөр буурсан байна.
- ✚ Сумдын цэцэрлэг сургуулийн хүүхдийн хоолны өр болон цалингийн нэмэгдэлийн 118.9 сая төгрөгөөр буурч бусад аж ахуйн материалын өр 160.5 сая төгрөгөөр буурсан
- ✚ ОНХСангийн өр 2.9 сая төгрөгөөр, сум хөгжүүлэх сангийн өр 15.5 сая төгрөгийн өглөг шинээр тус тус нэмэгдсэн байна.

Ийнхүү аймаг, сумдын Засаг дарга нар Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-т “Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхэд дараах шаардлага тавигдана”, 39.4.2-т “Өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Өр төлбөрийн задаргааг графикаар харуулбал:



Аймгийн нийт өр буурч байгаа ч ОНӨҮГ-ын өглөг төдийлөн буурахгүй ялангуяа татварын өр бусад тооцооны өрүүд жилээс жилд нэмэгдэж байна. Нийт өрийн дийлэнх хувийг байгууллагад өгөх өглөг 41 хувийг хувь хүнд өгөх өглөг 40 хувийг эзэлж байна.

10.2 Өр, төлбөрийн дансны үлдэгдлийн баталгаажуулалтын талаар

ОН-ийн санхүүгийн нэгтгэсэн хийсэн аудитаар буруу бүртгэсэн, бараа, ажил үйлчилгээг өглөгийн дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн, өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллага, иргэнтэй тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зэрэг нийт 559,3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Үүнд:

Аймгийн нэрс	Он дамжсан олон жилийн насжилттай авлага	Тооцоо нийлсэн актаар бат алгаажуулаагүй авлагын дүн	Залруулагдсан алдааны дүн
Алтай	2.2	1.8	
Булган	5.4	12.2	
Булнт	-	-	
Дарви	4.5	3.9	
Дуут	2.5	8.9	
Зэрэг	-	5.6	1.8
Мянхан	1.2	3.6	
Дэрген	-	-	
Мянгад	6.2	-	
Мяст	5.4	3.8	
Мяносайрхан	-	-	
Үенч	38.3	25.9	16.8
Ховд	1.2	-	12.2
Цэцэг	4.8	1.2	
Чандмань	4.8	7.5	96.1
ЭрдэнэБирэн	-	-	
Жаргалант	13.3	5.6	1.2
Ховд Аймаг	112.5	148.9	
Нийт дүн	202.3	228.9	128.1

- Сумдын айл өрхийг малжуулахад олгосон зээлийн эргэн төлөлтийг болон бусад байгууллага болон хувь хүмүүст олгох өрийг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан Зэрэг сумын 1.8 сая төгрөг, Үенч сумын 16.8 сая төгрөг, Ховд сумын 12,2 сая төгрөг, Чандмань сумын 9,6 сая төгрөг, Жаргалант сумын 1.2 сая төгрөг, нийт 128.1 сая төгрөгийн өрийг санхүүгийн тайланд бүрэн тусгаагүй, орхигдуулсан
- Аймаг сумдын өглөгийг он дамжсан олон жилийн насжилтаар авч үзэхэд Дарви сумын 4.5 сая төгрөг, Булган сумын 5,4 сая төгрөг, Үенч сумын 38.3 сая төгрөг, Алтай сумын 2.2 сая төгрөг, Цэцэг сумын 4.8 сая төгрөг, Мянгад сумын 6.2 сая төгрөг, Жаргалант сумын 13.3 сая төгрөг, Ховд аймгийн төвийн байгууллагуудын 112.5 сая төгрөг, Дуут сумын 2.5 сая төгрөг гэх мэт нийт 202.3 сая төгрөгийн өр төлбөр төлөгдөхгүй удааширсан
- Аймаг сумдын өглөгөөс Дарви сумын 3.8 сая төгрөг, Булган сумын 12.2 сая төгрөг, Зэрэг сумын 5.6 сая төгрөг, Дуут сумын 8.9 сая төгрөг, сумын 25.9 сая төгрөг, Цэцэг сумын 1.2 сая төгрөг, Жаргалант сумын 5.6 сая төгрөг, аймгийн 148.9 сая төгрөг нийт 228.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй

Дээрх байдал нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”, 19 дүгээр зүйлийн 19.1.4-т “...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах”, 19.1.5-д “эд хөрөнгө, өр төлбөрийн хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх” Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2-т “Өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтыг тус тус хангахгүй байгааг анхаарах

10.3 ОН-ийн ЗДТГ-уудад олгосон дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийн талаар

Гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн ЗДТГазарт олгосон зээлийг авч үзвэл Азийн хөгжлийн банкны 928.4 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа дуусаагүй байна..¹ /Доорх хүснэгтээс харна уу/

¹ Эх сурвалж: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс

Гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн ЗДТГ-т олгосон зээлийн судалгаа

(сая төгрөг)

№	Байгууллага	2016.12.31-ний өдрийн үлдэгдэл	Гэрээний огноо	Үндсэн төлбөр эхлэх хугацаа	Үндсэн төлбөр дуусах	Хугацаа хэтэрсэн /үндсэн/	хугацаа хэтэрсэн /хүү/	Үлдэгдэл	
								баталгаажуулсан	баталгаажуулаагүй
Азийн хөгжлийн банк									
23	Ховд аймгийн ЗДТГазарDZ 1560 MON(SF)	943,4	2003.12	2004.06	2018.12	662,0	290.5	943,4	-
НИЙТ ДҮН		943,4				662,0	290,5	943,4	

Эдгээр зээлийг аймаг, орон нутагт гэр хорооллын ус цэвэрлэх байгууламжийг сэргээн засварлах, газар доорх ус хангамж, ариутгалын систем, дэд бүтцийн тоног төхөөрөмжийг шинэчилж сайжруулах, зэрэг газруудыг төвлөрсөн системд холбож худаг гаргахад зориулан олгогдсон байна.

Арван нэг. Орлогын бүртгэл, тайлагнал

11.1 ОН-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Үзүүлэлт	Санхүүгийн үр дүнгийн тайлан			Мөнгөн гүйлгээний тайлан		
	2016 он	2017 он	зөрүү	2016 он	2017 он	зөрүү
Үйл ажиллагааны орлого	76,199.6	82,121.0	- 5,921.4	66,781.2	71,080.3	- 4,299.1
Татварын орлого	7,842.8	8,768.1	-925.3	7,842.8	8,768.1	-925.3
Татварын бус орлого	23,796.9	26,056.0	- 2,259.1	14,304.6	15,021.6	-717.0
Тусламж, санхүүжилтийн орлого	44,559.9	47,296.9	- 2,737.0	44,633.8	47,290.6	- 2,656.8

Санхүүгийн үр дүнгийн тайланд татварын орлого 8768.1, Татварын бус орлого 26056.0, тусламжийн орлого 44559.9 сая төгрөгөөр тайлагнасан нь өмнөх оноос 5921.4 сая, Мөнгөн гүйлгээний тайланд татварын орлого 71080.3, Татварын бус орлого 15021.6, тусламжийн орлого 47290.6 сая төгрөгөөр тайлагнасан нь өмнөх оноос 4299.1 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

11.2 Татварын болон татварын бус орлогын талаар

Тайлант онд 63083.8 сая төгрөгний орлого бүрдүүлэх төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 62651.6 сая төгрөгний орлого бүрдүүлж, батлагдсан орлогын төлөвлөгөөгөө 99.3 хувь буюу 432.1 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна. Орлого дутуу бүрдсэн шалтгаан нь орлогын төлөвлөгөөнд оны эхний үлдэгдлээс санхүүжүүлэх орлогод 1132.3 сая төгрөгийн төсөвт баталж өгсөнтэй холбоотой байна.

Үүнээс: Татварын орлогын төлөвлөгөөгөө 104.6 хувь буюу 7868.1, татварын бус орлого 98.4 хувь буюу 895.6, хөрөнгийн орлого 72.7 хувь буюу 67.3, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг буюу тусламжийн орлого 99.1 хувь буюу 52725.1 сая төгрөгөөр тус тус бүрдүүлсэн байна.

Аймгийн 2017 оны нийт орлогыг хүснэгтээр харуулбал: /сая төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	63,083.8	62,651.6	(432.1)	99.3
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	63,083.8	62,651.6	(432.1)	99.3

СУУРЬ ОРЛОГО	9,249.2	9,731.1	481.8	105.2
УРСГАЛ ОРЛОГО	9,109.2	9,663.7	554.5	106.1
ТАТВАРЫН ОРЛОГО	8,381.2	8,768.1	386.9	104.6
Орлогын албан татвар	6,163.6	6,588.0	424.3	106.9
Хувь хүний орлогын албан татвар	6,963.6	7,489.9	526.3	107.6
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	6,250.3	6,550.1	299.8	104.8
Үйл ажиллагааны орлого	217.2	203.2	(14.1)	93.5
Шууд бус орлого	496.1	736.6	240.5	148.5
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(800.0)	(902.0)	(102.0)	112.7
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(800.0)	(902.0)	(102.0)	112.7
Хөрөнгийн албан татвар	890.5	912.4	21.8	102.5
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	406.1	392.4	(13.7)	96.6
Бууны албан татвар	64.5	49.1	(15.4)	76.2
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	420.0	470.9	50.9	112.1
Бусад татвар, төлбөр, хураамж	1,327.1	1,267.7	(59.3)	95.5
Бусад нийтлэг төлбөр, хураамж	504.5	428.5	(76.0)	84.9
Улсын тэмдэгтийн хураамж	372.9	293.0	(79.9)	78.6
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	76.0	74.3	(1.7)	97.8
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	55.5	61.2	5.6	110.1
Газрын төлбөр	174.5	142.4	(32.0)	81.6
Газрын төлбөр	160.0	142.4	(17.6)	89.0
Дуудлага худалдаа	14.5	-	(14.5)	-
Байгалийн нөөц ашигласны төлбөр	648.1	685.4	37.2	105.7
Ойн нөөц ашигласны төлбөр	-	0.1	0.1	
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	486.1	500.7	14.6	103.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	122.5	150.9	28.4	123.2
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	39.6	33.7	(5.9)	85.2
Бусад татвар	-	11.5	11.5	
Бусад татвар	-	11.5	11.5	
Татварын бус орлого	53,290.7	52,876.7	(414.0)	99.2
Нийтлэг татварын бус орлого	728.0	895.6	167.6	123.0
Хувьцааны ногдол ашиг	15.0	8.2	(6.8)	54.7
Торгуулийн орлого	322.7	359.5	36.8	111.4
Төсөвт байгууллагын өөрийн орлого/ Орон нутаг	80.3	64.4	(15.9)	80.2
Бусад орлого	310.0	463.6	153.6	149.5
Хөрөнгийн орлого	140.0	67.3	(72.7)	48.1
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	140.0	67.3	(72.7)	48.1
Тусламжийн орлого	300.0	486.5	186.5	162.2
Хандив тусламж /дотоод/	300.0	486.5	186.5	162.2
Хандив тусламж /гадаад/	-	-	-	
Төсөвт байгууллагын өөрийн орлого /ТЗШ	207.0	195.5	(11.5)	94.4

Төсөвт байгууллагын өөрийн орлого /ТЗШ	207.0	195.5	(11.5)	94.4
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	51,915.7	51,231.7	(684.0)	98.7
Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт	40,264.4	40,266.4	2.0	100.0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	1,778.3	2,224.6	446.3	125.1
Аймгийн төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	8,740.7	8,740.7	(0.0)	100.0
Урьд оны үлдэгдлээс	1,132.3	-	(1,132.3)	-
СХС	1,411.9	1,006.9	(405.0)	71.3

Татварын орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Хувь хүний орлогын албан татвар 6963.6 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 7489.9 сая төгрөгний орлого бүрдүүлж 526.3 сая төгрөгөөр батлагдсан төлөвлөгөөгөө давуулсан байна. Энэ нь үйл ажиллагааны болон шууд бус орлогоо батлагдсан орлогын төлөвлөгөөнөөс 226.5 сая төгрөгөөр давуулж, цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 299.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэнээс шалтгаалсан байна. Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтыг 800.0 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч 902.0 сая төгрөгийн буюу 12.8 хувийг илүү олгосон нь байна.

Хөрөнгийн албан татвар 890.5 сая төгрөгний орлогын төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 912.4 сая төгрөгний орлого бүрдүүлж 21.9 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөгөө давуулсан нь үл хөдлөх хөрөнгийн албан татвар, бууны албан татварыг 29.1 сая төгрөгөөр тасалж, АТӨЯХ-албан татвар 50.9 сая төгрөгөөр батлагдсан орлогын төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэнтэй холбоотой байна.

Бусад татвар төлбөр хураамжийн орлогын төлөвлөгөөгөө 59.3 сая төгрөгөөр тасалсан нь улсын тэмдэгтийн хураамж 79.9, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1.7, газрын төлбөр 32.0, бүгд 113.6 сая төгрөгний татварын орлого тасалж, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 37.2, хог хаягдлын үйлчилгээний хураамж 5.6, бусад орлого 11.5 бүгд 54.3 сая төгрөгний орлого давуулан биелүүлсэн байна.

Татварын бус орлогын нэр төрлөөр авч үзвэл : Татварын бус орлогын төлөвлөгөө батлагдсан хэмжээнээсээ 167.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь хувьцааны ноогдол ашиг 6.8, төсөвт байгууллагын өөрийн орлого 16.6, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсаны орлого 72.7 бүгд 96.1 сая төгрөгөөр тасарч, торгуулийн орлого 37.5, тусламжийн орлого 186.5, бусад орлого 153.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэнтэй холбоотой байна. Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсаны орлого 51.9 хувиар буюу 72.7 сая төгрөгөөр тасарсан байна. Дээрх орлогыг төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан баталсанаас орлогын төлөвлөгөө тасарсан байна. Өмнөх онд сумдын ЗДТГ-т бүртгэлтэй цахилгаан моторуудыг зарж борлуулсантай холбоотойгоор орлого давж биелжээ.

Төсөвт байгууллагын өөрийн орлого /ТЗШ/-ийн 207.0 сая төгрөгний өөрийн орлого батлагдсанаас, гүйцэтгэлээр 195.5 сая төгрөгний орлого бүрдүүлж 11.5 сая төгрөгөөр тасалсан байна.

Орон нутгийн төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө 80.3 сая гүйцэтгэлээр 63.7 сая төгрөг бүрдүүлж 16.6 сая төгрөгөөр тасалжээ.

Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг :

Тусгай зориулалтын шилжүүлэг, Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого, Аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээр 49334,3 сая төгрөг авахаас, гүйцэтгэлээр 49294,7 сая төгрөгний санхүүгийн дэмжлэг авсан байна. Аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 39,7 сая төгрөгөөр дутуу авсан байна.


Ховд аймгийн татварын орлого, Татварын бус, Санхүүгийн дэмжлэгийг хүснэгтээр харуулбал:

Сумдын нэрс	Татварын орлого			Татварын бус			Санхүүгийн дэмжлэг		
	Төл	Гүй	зөрүү	Төл	Гүй	зөрүү	Төл	Гүй	зөрүү
Алтай	82.2	91.4	(9.2)	5.3	4.6	0.7	1,687.0	1,685.7	1.3
Булган	104.2	145.0	(40.7)	20.4	14.7	5.7	3,797.2	3,797.7	(0.5)
Буянт	56.5	61.3	(4.8)	2.6	3.5	(0.9)	1,528.9	1,528.9	(0.0)
Дарви	38.4	71.6	(33.2)	2.6	1.3	1.3	1,673.3	1,688.9	(15.6)
Дуут	48.1	53.8	(5.7)	2.6	4.4	(1.8)	1,319.6	1,307.7	11.8
Зэрэг	33.8	51.2	(17.5)	2.6	0.9	1.7	1,989.4	1,976.1	13.3
Манхан	57.2	60.8	(3.6)	0.6	0.9	(0.3)	2,087.0	2,074.1	12.9
Дөргөн	21.9	26.1	(4.1)	17.5	22.0	(4.5)	1,727.5	1,725.5	2.0
Мянгад	41.9	45.5	(3.6)	2.6	6.1	(3.5)	1,568.8	1,574.5	(5.6)
Мөст	131.8	138.3	(6.5)	14.2	14.2	(0.0)	1,479.5	1,483.5	(4.0)
Мөнххайрхан	30.1	39.5	(9.4)	2.6	2.2	0.4	1,462.1	1,459.9	2.2
Үенч	161.5	152.6	8.9	1.7	0.9	0.8	2,060.5	2,060.5	(0.0)
Ховд	23.7	30.7	(7.0)	2.6	3.0	(0.4)	1,766.3	1,764.3	2.0
Цэцэг	201.7	211.5	(9.8)	1.8	3.5	(1.7)	1,494.0	1,531.0	(37.0)
Чандмань	35.8	50.3	(14.5)	3.5	3.6	(0.1)	1,739.1	1,729.6	9.5
Эрдэнэбүрэн	35.5	40.3	(4.8)	2.6	2.9	(0.3)	1,509.1	1,509.6	(0.5)
Жаргалант	477.3	541.4	(64.0)	26.0	27.7	(1.7)	14,584.4	14,519.0	65.4
Төвлөрсөн	6,799.6	6,956.8	(157.2)	616.2	779.4	(163.2)	7,309.6	7,368.7	(59.1)
Нийт дүн	8,381.2	8,768.1	(386.9)	728.0	895.8	(167.8)	50,783.4	50,785.4	(2.0)

Татварын орлогыг Үенч сумаас бусад сум 3.6-аас 64.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Үенч сум нь дуудлага худалдааны орлогоор 14.5 сая төгрөгийг оруулна гэж тусгасан боловч дуудлага худалдааны орлогоо ЗДТГ-ын нэмэлт дансаар оруулан зарцуулсан байна.

Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүгийн дэмжлэгийн батлагдсан хэмжээнээс журнал ваучерээр 5 сумын төвлөрүүлэн захирагчид 62.7 сая төгрөгөөр илүү олгосон, 9 сумын төвлөрүүлэн захирагчидад 120.4 сая төгрөг дутуу олгосон нь батлагдсан төсвийг дураараа нэмж, хасч байгаа нь төсвийн төлөвлөлт бодитой бус байгааг харуулж байна.

Орлогын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулбал: Татварын орлого 925.3, Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 2554.4, Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 822.1, сум хөгжүүлэх сангийн орлого 1006.9 сая төгрөгөөр нэмэгдэж, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого 1439.5, татварын бус орлого 79.5 сая төгрөгөөр тус тус буурсан байна.



Нийт орлогын бүтцийг авч үзвэл: Татварын орлого 14%, Татварын бус орлого 2.6%, Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 64.3%, ОНХ-ийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого 3.6 %, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 13,9 %, СХС-гийн зээлийн эргэн төлөлтийн орлого 1.6 хувийг эзэлж байна. Санхүүгийн тайлангийн аудитаар орлого данстай холбоотой дараахь зөрчил илэрлээ. Үүнд :

- ✚ Дарви сумын ЗДТГ нь байгаль хамгаалах сан нэртэй дансыг ХААН банкинд нээж хөшөөтийн нөлөөллийн бүсийн урамшуулалд 89.5 сая төгрөгийг авсан боловч тайланд тусгаагүй, арилжааны банкинд зөвшөөрөлгүйгээр данс нээсэн нь Төсвийн тухай хуулийн 34.4-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бичгээр ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр банк аливаа төсвийн байгууллагад данс нээхийг хориглоно”, 25.7-д “Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана”, 25.12-т “Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тусламжийн орлогыг төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5-д “бүх орлогыг нягтлан бодох бүртгэлд заавал тусгана” гэсэн заалтуудтай нийцээгүй, аймгийн татварын орлогод орох 10.8 сая төгрөгийн орлогыг сумын татварын орлогод шилжүүлэн авч зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 23.6-д “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татварын орлогоор аймаг, нийслэлийн татварын орлого бүрдэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна. Мөн Кама, ковш тээврийн хэрэгсэлүүдийг түрээсээр эзэмшүүлдэг боловч орлогыг санхүүгийн тайлан балансад тусгаагүй, гэрээг дүгнээгүй, хэдэн төгрөг орж ирсэн нь тодорхой бус байна.
- ✚ Үенч сум нь төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсаны 14.0 сая төгрөгийн орлогыг ЗДТГ-ын нэмэлт дансанд төвлөрүүлэн зарцуулсан, ойн сангаа 19.8 сая төгрөгөөр худалдсан ч орлогыг мөн татварын орлогын дансаар дамжуулахгүйгээр нэмэлт дансаар дамжуулан зарцуулсан байна.
- ✚ Цэцэг сум нь ангийн орлогод 175.8 сая төгрөг баталсан байхад гүйцэтгэлээр 186.5 сая төгрөг оруулж 10.6 сая төгрөгөөр илүү оруулсан, тодотгол хийлгээгүй зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах заалтыг зөрчиж байна

Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал**12.1 Зардлын бүтцийн талаар:**

Тайлант онд 63083.8 сая төгрөгний зардлын төлөвлөгөөтэйгээс, гүйцэтгэлээр 61625.2 сая төгрөгний зардал гаргаж батлагдсан зардлын төлөвлөгөөг 1458.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Ховд аймгийн 2017 оны Төсвийн гүйцэтгэлийн тайланг харуулбал : /сая төг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	63,083.8	61,625.2	1,458.6	97.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,986.8	58,493.5	493.3	99.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,595.4	45,117.0	478.5	99.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,565.2	29,558.9	6.3	100.0
210101	Үндсэн цалин	23,230.1	23,491.3	(261.2)	101.1
210102	Нэмэгдэл	3,301.4	3,105.6	195.9	94.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59.1	57.3	1.8	96.9
210104	Урамшуулал	1,522.7	1,508.4	14.3	99.1
210105	Гэрээт ажлын хөлс	1,451.9	1,396.5	55.5	96.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,256.6	3,273.8	(17.2)	100.5
210201	Тэтгэврийн даатгал	2,070.1	2,092.0	(22.0)	101.1
210202	Тэтгэмжийн даатгал	272.3	252.9	19.4	92.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	263.7	272.9	(9.2)	103.5
210204	Ажилгүйдлийн даатгал	59.1	65.2	(6.0)	110.2
210205	Эрүүл мэндийн даатгал	591.4	590.8	0.7	99.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,643.5	4,482.4	161.1	96.5
210301	Гэрэл, цахилгаан	568.2	545.6	22.6	96.0
210302	Түлш, халаалт	3,583.8	3,459.3	124.5	96.5
210303	Цэвэр, бохир ус	488.8	473.9	14.9	96.9
210304	Байрны түрээс	2.7	3.5	(0.8)	131.3
2104	Хангамж, бараа материалын зардал	1,166.5	1,357.3	(190.8)	116.4
210401	Бичиг хэрэг	111.4	154.9	(43.5)	139.0
210402	Тээвэр, шатахуун	614.5	693.3	(78.8)	112.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	128.6	128.5	0.1	100.0
210404	Ном, хэвлэл	25.8	29.0	(3.2)	112.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	121.1	108.0	13.1	89.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	165.1	243.6	(78.5)	147.5
2105	Нормативт зардал	2,780.1	2,688.5	91.6	96.7

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	236.4	245.6	(9.2)	103.9
210502	Хоол, хүнс	2,419.0	2,319.0	100.1	95.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	124.6	124.0	0.7	99.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	285.4	319.9	(34.5)	112.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	37.2	37.9	(0.7)	101.9
210602	Тавилга	-	2.0	(2.0)	
210604	Урсгал засвар	248.2	280.0	(31.8)	112.8
2107	Томиллолт, зочны зардал	184.3	210.1	(25.8)	114.0
210702	Дотоод албан томиллолт	184.3	209.5	(25.2)	113.7
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	0.6	(0.6)	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,220.7	1,144.3	76.4	93.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,158.9	1,058.6	100.3	91.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	19.2	45.8	(26.6)	238.4
210803	Даатгалын үйлчилгээ	6.4	6.3	0.1	97.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	8.3	9.1	(0.8)	109.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.9	1.1	(0.2)	116.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11.3	14.2	(2.9)	125.9
210807	Газрын төлбөр	3.0	2.9	0.2	94.4
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	12.5	6.2	6.3	49.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,493.2	2,081.8	411.4	83.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,258.4	1,886.1	372.4	83.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	234.8	195.7	39.0	83.4
212	ТАТААС	574.0	573.8	0.2	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	50.3	50.1	0.2	99.6
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	50.3	50.1	0.2	99.6
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	523.7	523.7	0.0	100.0
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	523.7	523.7	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,817.4	12,802.7	14.6	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,817.4	12,802.7	14.6	99.9
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	7,349.3	7,359.6	(10.4)	100.1
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9.8	11.3	(1.5)	114.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,165.0	1,136.1	28.9	97.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,137.6	1,107.4	30.2	97.3
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,018.6	2,006.8	11.8	99.4

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,137.1	1,181.5	(44.4)	103.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,418.4	2,268.3	150.1	93.8
2200	Дотоод эх үүсвэрээр	2,418.4	2,268.3	150.1	93.8
220001	Барилга байгууламж	373.3	334.0	39.3	89.5
221001	Их засвар	648.4	432.5	215.9	66.7
222001	Тоног төхөөрөмж	476.1	496.6	(20.5)	104.3
223001	Бусад хөрөнгө	920.5	1,005.2	(84.7)	109.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,678.6	863.4	815.2	51.4
230001	Эргэж төлөгдөх зээл	1,678.6	863.4	815.2	51.4
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	63,083.8	62,045.4	1,038.4	98.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,634.9	40,618.1	16.7	100.0
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	370.5	351.8	18.7	94.9
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	40,264.4	40,266.4	(2.0)	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19,417.7	18,985.6	432.2	97.8
132001	Орон нутгийн төсвөөс	17,501.8	17,207.3	294.5	98.3
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,915.9	1,778.3	137.6	92.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,031.1	2,441.7	589.5	80.6
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	208.1	207.2	1.0	99.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,515.0	1,506.0	9.0	99.4
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,008.0	241.9	766.1	24.0
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	300.0	486.5	(186.5)	162.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	577.9	(577.9)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	998.1	(998.1)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	149	149	-	100.0
610001	Төсвийн байгууллага	131	131	-	100.0
610002	Төсвөөс гадуур байгууллага	18	18	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3,881	3,878	3.0	99.9
620001	Удирдах ажилтан	265	264	0.5	99.8
620002	Гүйцэтгэх ажилтан	2,265	2,270	(5.5)	100.2
620003	Үйлчлэх ажилтан	879	880	(1.0)	100.1
620004	Гэрээт ажилтан	473	464	9.0	98.1
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	11,574	11,731	(157.0)	101.4
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	9,010	9,178	(168.0)	101.9
630001	Төрийн өмчит ЕБС	8,367	8,535	(168.0)	102.0
630002	Хувийн ЕБС	643	643	-	100.0

631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	2,564	2,553	11.0	99.6
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	2,552	2,541	11.0	99.6
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага	12	12	-	100.0

Зардлын зүйл анги тус бүрээр нь авч үзвэл: Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 29565.2 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс, гүйцэтгэлээр 29558.9 сая төгрөгний зардал гарч батлагдсан төсөвт зардлаа 6.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь үндсэн цалин 261.2 сая төгрөгөөр хэмнэж, нэмэгдэл 195.9, унаа, хоолны хөнгөлөлт 1.8, урамшуулал 14.3, гэрээт ажлын хөлс 55.5 бүгд 267.4 сая төгрөгөөр хэтрүүлсэнтэй холбоотой байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл батлагдсан төсөвт зардлаасаа 17.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал 4643.5 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 4482.4 сая төгрөгний зардал гарч 161.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Үүнд: гэрэл цахилгаан 22.6, түлш халаалт 124.5, цэвэр бохир ус 14.9 сая төгрөгөөр тус тус хэмнэж байрны түрээсийг 0.8 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Хангамж, бараа материалын зардалд 1166.5 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 1357.3 сая төгрөгний зардал гаргаж 190.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Үүнд: бичиг хэрэг 43.5, тээвэр шатахуун 78.8, ном хэвлэл 3.2, Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс 78.5 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулжээ.

Нормативт зардал 2780.1 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 2688.5 сая төгрөгний зардал гарч, төсвөө 91.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Үүнд: Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл 9.2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж, хоол хүнс 100.1, нормын хувцас, зөөлөн эдлэл 0.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Эд хогшил урсгал засварын зардал батлагдсан хэмжээнээсээ 34.5 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь багаж техник хэрэгсэл 0.7, тавилга 2.0, урсгал засвар 31.8 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэнтэй холбоотой байна.

Томилолтын зардал 25.8 сая төгрөгөөр хэтэрсэн боловч гадаад томилолтонд нэг ч төгрөг төсөвлөгдөөгүй байхад 48.9 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1220.7 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 1144.3 сая төгрөг зарцуулж төсвөө 76.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Үүнээс мэдээлэл, технологийн үйлчилгээ 2.9 сая, аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал 26.6, тээврийн хэрэгсэлийн татвар 0.8, сая төгрөгөөр тус тус хэтрүүлж бусад даатгалын үйлчилгээ, банк санхүүгийн үйлчилгээний хураамж, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, газрын төлбөрийн зардлууд хэмнэгдсэн байна.

Бараа үйлчилгээний бусад зардалд 2493.2 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 2081.8 сая төгрөгний зардал гаргаж батлагдсан төсвөө 411.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас 523.7 сая төгрөгөөр батлагдаж батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргасан байна.

Урсгал шилжүүлгийн зардалд 12817.4 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 12802.7 сая төгрөгний зардал гаргаж 14.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Үүнд: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж 10.4, нэг удаагийн тэтгэмж урамшуулалын тэтгэмжийг 44.4 сая төгрөгөөр хэтрүүлж, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал 28.9, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 30.2, хөдөө орон нутагт тогтвортой суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 11.8 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Хөрөнгийн зардалд 2418.4 сая төгрөгний төсөв батлагдаж гүйцэтгэлээр 2268.3 сая төгрөг зарцуулж 150.1 сая төгрөгөөр төсвөө хэмнэсэн байна. Үүнд: барилга байгууламж 39.3, их засвар 215.9 сая төгрөгөөр хэмнэж тоног төхөөрөмж 20.5, бусад хөрөнгө 84.7 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Эргэж төлөгдөх зээлийн зардалд 2011 оноос сумдуудад жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэхэд зориулан олгосон зээлээс 2017 онд 1678.6 сая төгрөг олгохоор төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 863.4 сая төгрөгний зээл, төлөвлөгдсөн хэмжээнээс 815.2 сая төгрөгний зээл олгоогүй байна.

12.2.1 Бараа үйлчилгээний зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

✚ Дарви сумын ЗДТГ нь цалингийн зардлаас 33.4 сая төгрөгийг бараа ажил үйлчилгээний бусад зардалд зөвшөөрөлгүйгээр зарцуулсан, дарви сумын хүүхдийн цэцэрлэг нь хоолны зардлаас 11.8 сая төгрөгийг бараа ажил үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байгаа нь Сангийн сайдын 2017 оны 216 тоот тушаалтай нийцэхгүй байна.

✚ Аудитын явцад хийсэн судалгаагаар цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал, сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 104.3, үдийн цайны хүүхэд өдрийн тооноос бий болсон 117.5 бүгд 228.1 сая төгрөгийн төсвийн хэмнэлтийг бараа ажил үйлчилгээний бусад зардалд гүйлгэн нь Сангийн сайдын 2017 оны 216 тоот тушаалын 2.2.1-д



“нэгжид ногдох норм, нормативаар тооцсон төсвийн гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээ багассанаас бий болсон үлдэгдлийг төсвийн зарлагын хэмнэлтэнд тооцохгүй” гэсэн заалттай нийцэхгүй байна. Аймгийн хэмжээгээр хоолны зардалд 2017 онд 2419.0 сая төгрөг төсөвлөгдөж, 2319.0 сая төгрөгийг зарцуулж 100 сая төгрөг хэмнэсэн гүйцэтгэл гарсан байна. Аудитаар цэцэрлэг болон байрны хүүхдүүдийн хоолонд хориглосон хүнсний бүтээгдэхүүн болох хиам, өндөг, майноз зэргийг хэрэглэсэн тохиолдлууд илэрч албан шаардлага өгөгдсөн байна.

✚ Томилолтын зардал 25.8 сая төгрөгөөр хэтэрсэн боловч гадаад томилолтонд нэг ч төгрөг төсөвлөгдөөгүй байхад 48.9 сая төгрөгний зардал гаргаж тайланд тусгаагүй байна. Аудитын хугацаанд хийгдсэн судалгаагаар гадаад томилолтын зардалд 48.9 сая төгрөгийн зардал гаргасан байна. Үүнд: Аймгийн ЗДТГ, аймгийн ИТХ, Дарви сум гадаад томилолтоор ажилласан ч гадаад томилолтын зардалд тайлагнаагүй байна.

✚ Төсвийн захирагчийн буруутай үйл ажиллагаанаас ажлаас халагдсан хүмүүсийн цалин буцаан олгож төсвийн зардал гаргасан алдааг тайлант онд мөн давтан гарсаар байна. Тухайлбал: Аймгийн

✚ Орон нутгийн төсөвт байгууллагууд шатахууны зардалд 614.5 сая төгрөг батлагдсанаас 693.2 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвөө 91,1 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан байна. Шатахууны зарцуулалтанд тавих хяналт сул зөвхөн байгууллагын дарга, нягтлан бодогчийн зөвшөөрлөөр олгогдож байгаа нь няраваас тавих хяналт байхгүй, жолоочийн замын хуудас бүрэн бичүүлээгүй, нягтлан бодогч жолоочийн тооцоог боддоггүй зөрчил түгээмэл байна.

✚ Урсгал зардалд 248.1 сая төгрөг батлагдаж 279.9 сая төгрөг зарцуулж батлагдсан зардлаа 31.8 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна

✚ 2017 онд цалингийн зардлыг өмнөх оноос 153.9 сая төгрөгөөр илүү зарцуулсан байгаа нь УИХ-ын 2017 оны 29 дугаар тогтоолын 4 дүгээр заалтын “төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах...”, УИХ-ын 2016 оны 47 тогтоолын 2-ын а-д “бүх

шатны төсвийн захирагч нарт салбар болон байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах зэргээр орон тоо, цалин хөлс...бууруулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

- ✚ Хувь хүний орлогын албан татварын буцаалтын гүйцэтгэл нь батлагдсан төсвөөс 102.0 сая төгрөгөөр хэтэрч гарсан боловч уг хэтрэлтийг санхүүгийн тайлан балансад орлого бууруулахгүйгээр бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.6-д “бүх зардлыг нягтлан бодох бүртгэлд заавал тусгана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Арван гурав. Засаг дарга, ОНХС, ОНХО, Өмчийн сан дансдын талаар

13.1 Орон нутгийн хөгжлийн сан дансны талаар

2017 оны орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг 2017 оны 4 дүгээр хуралдааны 02/3 тоот тогтоолоор сумдын ОНХС-д 918,1 сая, аймгийн ОНХС-д 860,2 сая, бүгд 1778.3 сая төгрөгөөр баталжээ.

Сумдад 2017 онд ОНХС-ийн хөрөнгөөр 918,1 сая төгрөг хуваарилагдсаныг сумдын ИТХ-ын хурал, нийт багийн иргэд нийтийн хурлаар хэлэлцүүлэн иргэдийн гарсан саналыг эрэмбэлэн нэн шаардлагатай хөрөнгө оруулатанд зарцуулахаар сумдын ИТХ-ын 2017 оны 12 сарын сүүлчээр хуралдсан хурлаараа төсөл арга хэмжээ нэг бүрээр батлан хэрэгжүүлжээ. Он дамжсан ажлууд ихээхэн байсан зэргээс хамааран зарим сумдын ихэнх санхүүжилт өмнөх оны ажилд зарцуулагдахаар төсөвлөгдсөн байна.

ОНХС-ийн шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сумын ОНХС-д хуваарилахаар хуульчилсан байхад аймаг орлогын шилжүүлгийг сумдад хуваарилахдаа уг заалтыг хэрэгжүүлээгүй 148.8 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Тайланд онд аймгийн ОНХС-д 88,1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэлтэй байсан бол ОНХС-гаас 1778.3 сая төгрөгийн санхүүжилт ирж, 1863.8 сая төгрөгийн зарлага санхүүжүүлж оны эцэст 2.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Аймгийн ОНХС-гийн эх үүсвэрээр нийт 24 ажил төлөвлөснөөс 4 ажил нь өмнөх оны дутуу ажлууд 69 ажил нь шинээр эхлэх ажлууд байна.

Аудитаар аймгийн ИТХ-аар нийт 34 төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн бөгөөд төсөл арга хэмжээний жагсаалтанд ороогүй, иргэдийн санал аваагүй зарим төсөл арга хэмжээг санхүүжүүлжээ. Үүнд:

- ✚ Аймгийн ИТХ-аар нутгийн өөрөө удирдах байгууллагыг чадавхижуулах хөтөлбөр, багшийн хөгжил, авъяас, ном, алтан өв, аварга, нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх хөтөлбөр, амны хөндийн эрүүл мэнд хөтөлбөр, гэр бүлийн хөгжил хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, мөнгөлөг шагшуурга өвлийн урлаг спортын хөтөлбөр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн дэд хөтөлбөр, залуучуудыг дэмжих хөтөлбөр, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр, ажилтай орлоготой ховд хүн дэд хөтөлбөр зэрэг хөтөлбөрүүдийг баталж хэрэгжүүлж байна. Энэ нь Сангийн сайдын ОНХС-гийн 2014 оны 43 тоот тушаалын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын чиглэлтэй нийцэхгүй байна.
- ✚ Засаг даргын нөөц хөрөнгөөс өвсний нөөц бүрдүүлэх ажлыг аймгийн ОНХС-аас Эко Ховд ХХК 5.3 сая төгрөгөөр бэлтгэжээ.
- ✚ ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхижуулах хөтөлбөрт 80.0 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”-г санхүүжүүлэхийг хориглосон заалтыг зөрчсөн

- ✚ Концесийн гэрээгээр хэрэгжиж байгаа Баатархайрхан багийн өрхийн эмнлэгийн санхүүжилтийг ОНХС-гийн хөрөнгөнөөс “Дабль сервис” ХХК-д 35.0 сая төгрөг, Аргаль уриа ЦТП, Галдан бошигт хааны нэрэмжит гудамжны 30.0 сая төгрөг олгосон нь Төсвийн тухай хууль болон ОНХСангийн заавар журмыг зөрчсөн.
- ✚ Сутай үйлдвэрийн данс руу 2.8 сая төгрөг, ХХААГ-т Мянгад омгийн адуу судалгааны 5.5 сая төгрөг төлсөн нь анхан шатны баримтгүй, Тунгалаг бүртгэл хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажил болох 6.3 сая төгрөгийн зарцуулалт А.Оюундэлгэрийн хувийн харилцах дансруу орсон, 15.1 сая төгрөгийн хөрөнгө авч 9.9 сая төгрөг Э.Ууганбаяр хувь хүний харилцах руу, 5.1 сая төгрөг Бат-Арвижих ЗБН данс руу шилжүүлж ИТХ-ын тогтоол шийдвэргүй хөрөнгө бэлтгэсэн, хувь хүний харилцах данс руу шилжүүлсэн, зарим олгосон санхүүжилт болох 208.1 сая төгрөг анхан шатны баримтын бүрдэл дутуу, хийсэн ажлын тайлан иж бүрэн биш байна.
- ✚ 2014 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн Сангийн сайдын 43 тоот тушаалаар батлагдсан” орон нутгийн хөгжлийн сангийн журмын 4.2-дахь заалт “Тухайн орон нутгийн иргэдийн санал авч зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн байх, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авалтуудыг зохион байгуулаагүй ЗДТГ-ын уулзалтын өрөө, иргэний танхим тохижуулах 30.0 сая төгрөг, хөтөлбөр арга хэмжээнд тусгагдаагүй БОЭТ-ийн тоног төхөөрөмж авсан 30.5 сая төгрөгийн хөрөнгө авч бэлтгэсэн
- ✚ ОНХСангаас санхүүжүүлсэн Буянт тэгш үйлс ХХК-аас ЗДТГ-ын уулзалтын өрөө тохижуулсан 25.6 сая төгрөг, Мото медиа ХХК-ны иргэний танхим тохижуулсан 10.0 сая төгрөг, Бат-Арвижих ЗБН-ийн тавилга авсан 5.1 сая төгрөгийн хөрөнгө ИТХ-ын тогтоол шийдвэргүй байна
- ✚ ОНХСангийн санхүүжилт хувь хүний харилцах данс руу шилжүүлсэн мөнгөний 10% -ийн ХАОАТ болох 1.5 сая төгрөг суутгаж аваагүй байна.

Аймаг сумдын ОНХС-гаар хийгдэх ажлуудын зураг төсвийг хийлгэсэн байна. Аймгийн ОНХС-гаас 200.9 сая төгрөгийн зураг төсөв хийлгэж, аймгийн хэмжээнд 754.7 сая төгрөгийн зураг төсвийн авлагыг бүртгэжээ. Тайланд онд 21.4 сая төгрөгийн зураг төсвийн авлага барагдсан байна.

ОНХС-гийн зарим сумдын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь тайлант онд сумандаа хэрэгжиж байгаа ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл арга хэмжээнд хяналт шалгалтыг хийж сумдын засаг дарга нарт холбогдох үүргийг өгч ажиллаагүй байна. Захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн сумдын ОНХС-гийн зарцуулалтанд алдаа зөрчил бага илэрч хяналт хэрэгжүүлээгүй сумдад алдаа дахин давтан гарсаар байна.

Өмнөх оны ОНХС-гийн аудитаар зөвлөмж болгон өгсөн 2014 онд хэрэгжүүлсэн 270.0 сая төгрөгийн төмс боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулалтын ажлыг одоог хүртэл данс бүртгэлд тусгаагүй байна.

Мөн өмнө онуудад өгөгдөж байсан өвс, махны нөөц бэлтгэхэд зориулан олгосон мөнгөн хөрөнгийг ОНХС-гийн дансанд буцаан төвлөрүүлэх зөвлөмж өгөгдсөн боловч одоог хүртэл бүрэн төвлөрөөгүй байна.

13.2 Орон нутгийн хөрөнгө оруулалтын дансны талаар:

2017 онд аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 456.8 сая төгрөг батлагдаж тодотголоор 524.9 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд орлогын дансаар төслөөс 242.0 сая, Цэцэг сумаас 40.7 сая бүгд 282.8 сая төгрөг орж төсвөөс 174.3 сая төгрөг, барьцаа хөрөнгөөс 72.9 сая, бүгд 530.1 сая төгрөг бүрдүүлж зарцуулжээ.

Аудитаар дараах алдаа зөрчил илэрлээ.

- ✚ ОНХО-ын жагсаалтанд орж ИТХ-аар батлуулаагүй мөртлөө ЗДТГ-т суудлын авто машин авах, Булган суманд машин засварын үнэ нийт 40.5 сая төгрөгийн ажлуудыг ОНХО-ын данснаас санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.
- ✚ ОНХО-ын данснаас 8 сарын 14-ны өдөр дараа тооцоогоор урьдчилгаа 10.0 сая төгрөг ЗДТГ-ын Голомт банкны түр дансанд шилжүүлж 9 сарын 4-ны өдөр Ганболдоос гэсэн нэрээр орлогын дансанд орсон. Ямар зориулалтаар гарсан тухай анхан шатны баримт байхгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “Дансны өглөг авлага, ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээ гарахаас нь өмнө, хянан баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
- ✚ Жаргалант луу ХХК-10.4, Буянт стандарт ХХК-60.9, Элэг энэрэл ХХК-0.9, Улаан дөл ХХК-0.5, бүгд 72.9 сая төгрөгийн барьцааны мөнгийг 2017 оны 02 сарын 07-ны өдрийн төлбөрийн хүсэлтээр ЗДТГ-т шилжүүлж 05 сарын 23-ны өдөр барьцааны буцаалт ХААН банкнаас орлогоор орж ирсэн. Банкинд байршуулсан хүүний орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайд, Монгол банкны ерөнхийлөгчийн хамтарсан 2013 оны 24/24/А-9 тоот журмын 3 дугаар заалтанд заагдаагүй үйл ажиллагаанд данс нээсэн, 3.5.Төсвийн байгууллага банкинд данс нээлгэх тухай хүсэлтийг дараахь мэдээллийн хамт албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хаяглан ирүүлнэ. Үүнд: 3.5.1.данс нээлгэх шаардлага; 3.5.2.аль банкинд ямар төрлийн данс нээлгэх тухай санал; 3.5.3.данс нээлгэх гэж буй банкны тухай энэхүү журмын 3.2-т заасан мэдээлэл; 3.5.4.шаардлагатай нэмэлт мэдээлэл. 3.6.Банкинд данс нээхийг зөвшөөрсөн тохиолдолд Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан бичгийг үндэслэн банк тухайн төсвийн байгууллагын нэр дээр дансыг нээнэ гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

13.3 Орон нутгийн өмчийн сангийн талаар:

Орон нутгийн өмчийн сангийн дансаар 2017 онд 127.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн бөгөөд дэнчингээр 55.0 сая, түрээсийн орлогын 20 хувь 7.4 сая, тендерийн материалын үнэ 2.4 сая, хөрөнгө дуудлага худалдаагаар зарсны 61.8 сая, бусад орлого 0.3 сая төгрөг орж зарлага гаргажээ.

Аудитаар дараах алдаа зөрчил илэрлээ.

- ✚ Хөрөнгийн түрээс, акталсан машины дуудлага худалдаанаас орох орлого нийт 87.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж үүний 10 хувийг аймгийн ИТХ-ын 2017 оны 93 тоот тогтоолоор баталсан журмын дагуу 8.7 сая төгрөгийг зарцуулах эрх үүссэн байхад 12.7 сая төгрөг зарцуулж 4.1 сая төгрөгийг кассаар бэлнээр авч зориулалт бусаар зарцуулсан байна.
- ✚ Дуудлага худалдаагаар борлуулсан 2 машины орлого аймгийн өмчийн сангийн орлогоор татагдах байсныг тусгайлан ИТХын тогтоол гарган аймгийн ЗДТГ-т 80 хувь болох 11.6 сая төгрөгийг шилжүүлсэн байна.
- ✚ Өмчийн сангийн нэмэлт данснаас үйл ажиллагааны зардал болох НДШ-ийн 2.1 сая төгрөгийг зарцуулсан байна.
- ✚ Өмчийн сангийн авлага болох 64.3 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж баримтжуулаагүй байна.

13.4 Засаг дарга дансны талаар:

Тайлант онд Засаг дарга дансанд 724.8 сая төгрөгийн санхүүжилт олгож тухайн дүнгээр үйл ажиллагааны зардал санхүүжүүлсэн байна.

Засаг дарга дансанд илэрсэн зөрчлүүд:

- ✚ 2017 онд аймгийн Засаг дарга данснаас Эко бие засах газрын өтгөн зөөвөрлөх авто машин, ажлын хувцас нийлүүлэх ажлын эцсийн санхүүжилт олгох, хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авах комиссын актыг хянан шалгахад гэрээний санхүүжилт 19.9 сая төгрөгийн үнийн дүнтэй, урьдчилгаа төлбөрийг 2016 онд 14 сая төгрөг олгосон байна. Уг компани худалдан авах үйл ажиллагаанд оролцоходоо санал болгосон машинаа ирүүлээгүй машины хувьд хэтэрхий он хөгшин, запас дугуй муу зэрэг техникийн тодорхойлолтыг хангаагүй бараа хүлээн авсан. Мөн ашиглагч байгууллага хөрөнгө хүлээн авах тушаал шийдвэр байхгүйн улмаас данс бүртгэлд тусгаагүй байгаа зөрчил дутагдал нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт зөрчсөн.
- ✚ Замын сангийн хөрөнгөөр 2017 онд хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтаар Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын дагууд явган хүний замын уртыг 3.1 км–ээр нэмэгдүүлэх 2 дугаар багц ажил 75.0 сая төгрөгийн төсөвтэй, ажлын даалгавартай ирсэнийг үнэлгээний хороо байгуулан тендер зарлаж Зол дайчин ХХК-тай 1.4 сая төгрөгийн үнийн хөнгөлөлт үзүүлж 69.6 сая төгрөгөөр гэрээ байгуулсан байна. Ажил гүйцэтгэх явцад аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газраас стандартын дагуу авто зам, явган хүний замыг тусгаарлах арга хэмжээ авч хийж гүйцэтгэсэн ажлын талаар хариу мэдэгдэх албан тоот ирүүлсний дагуу ажил зогссон байна. Хийгдээд байсан 810 метр замыг дахин хуулж, бордюрыг нэмэлтээр босгож гүйцэтгэсэн, шорооны дүүргэлт хийснээс тээврийн хөлс, ажилчдын цалин нэмэгдсэн зэрэг шалтгаанаар анхны төсөвт өртөгт тааруулан 2 км явган хүний зам хийж хүлээлгэн өгсөн байна. Одоогоор энэ хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна. Мөн Жаргалант сум доторх зам засварын 1 дүгээр багц ажлыг 98.3 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээг Түм дэлгэрэх ХХК-тай байгуулсан байна. Эдгээр 2 ажлын тендер зарлахдаа тухайн ажлын зураг төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох баримт материалыг иж бүрэн бүрдүүлээгүй тендер зарлах шаардлага хангаагүй байхад зарлаж байгаа зөрчил дутагдал нь Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19.2.”Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана”, 41.1.2.энэ хуулийн “40.4-т зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх”, 46.1.7. ”хууль, гэрээнд зааснаас бусад тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулахгүй байх”, 46.1.9.”гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний баталгаат хугацааны туршид заавал байрлуулахыг шаардах” зэрэг заалтуудыг зөрчиж байна.
- ✚ Байгаль хамгаалах сангаас Ховд аймгийн Ерөнхий агнуур зохион байгуулалт хийх, агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлын гэрээг Уламжлалт ав ХХК-тай 9.9 сая төгрөгөөр санхүүжилтын гэрээ байгуулж 70 хувийн урьдчилгаа 6.9 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Уг ажлыг 2017.11.25-нд дуусгаж хүлээлгэн өгөхөөр гэрээний тусгай нөхцөлд заасан боловч хугацаандаа хүлээлгэн өгөөгүй байна. Тайлант онд уг ажил гүйлгээтэй

холбоотой 6.9 сая төгрөгийн авлага бүртгээгүй байгаа зөрчил дутагдал нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйл.Захиалагчийн эрх, үүрэг 46.1.6.бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

- ✚ Тайлант онд Албан журмын даатгагчдын холбоонд АТБӨЯХАТ-ын орлогын 10 хувийн төвлөрүүлэлт 37.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Жолоочийн даатгалын сангийн хөрөнгө зарцуулалтын талаар хамтран ажиллах гэрээг аймгийн Засаг даргатай байгуулж хөрөнгийн орлого түүний зарцуулалтын гүйцэтгэлийн тайланг гаргаж ирүүлээгүй зөрчил дутагдал нь Хамтран ажиллах гэрээний 3.1.3-д “жолоочийн даатгалын санд аймгийн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгийн орлого, түүний зарцуулалтын гүйцэтгэлийн тайлан мэдээг улирал тутам, санхүүгийн нэгдсэн тайланг хагас бүтэн жилээр гаргаж , МУ-ын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон төсвийн тухай хуулинд заасан хугацаанд аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлнэ” гэснийг зөрчиж байна.

Арван дөрөв. ОН-ийн өмчит үйлдвэрийн газрын бүртгэл, тайлагнал
14.1 ОНӨҮГ-ын бүтцийн талаар

ОН-ийн ТЕЗ-дын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “Шим Ус “ ОНӨҮГ, “Эрч хүч” ОНӨҮГ, “Чандмань Бит төв”, “Ховд Суврага” ОНӨҮГ, “Мянган Угалзат “ОНӨҮГ, “Тээлийн илч” ОНӨААТҮГ, “Мянгад Шим-Ус” ОНӨААТҮГ, “Минжит булган” ОНӨААТҮГ, Үенч Эрчим хүч зэрэг 10 ОНӨҮГ-ын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Хүснэгтээр харуулбал: / сая төгрөгөөр/

	Чандмань Бит төв	Мянган Угалзат ОНӨҮГ	Ховд суврага	Шим-Ус ХХК	Ховд эрч хүч	Эв эийн хүч	Үенч эрчим хүч	Тээлийн илч	Мянгад шим ус	Минжит булган	Нийт
Орлого	1.3	180.0	96.2	1283.0	185.9			51.0	12.9	15.9	1,826.2
Зарлага	9.4	222.9	114.0	1273.2	267.5		683.3	51.4	12.6	14.9	2,649.2
2017 оны үр дүн	-8.1	-42.9	-17.8	9.8	-81.6	0.0	-683.3	-0.4	0.3	1.0	-823.0
Өмнөх үеийн үр дүн	-35.1	-35.7	1482.9	-908.7	81.6	0.3	-	1012.9			-427.6
Хуримтлагдсан үр дүн	-43.2	-78.6	1465.1	-898.9	0.0	0.3	-	-0.4	0.3	1.0	-
							1696.2				1,250.6

ОНӨААТҮГ-ууд тайлант онд 1826.2 сая төгрөгний орлого бүрдүүлж 2649.2 сая төгрөгний зардал гаргаж /- 823.0/ сая төгрөгний алдагдалтай ажилласан байна.

	Чандмань Бит төв	Мянган Угалзат ОНӨҮГ	Ховд суврага	Шим-Ус ХХК	Ховд эрч хүч	Эв эийн хүч	Үенч эрчим хүч	Тээлийн илч	Мянгад шим ус	Минжит булган	Нийт
Мөнгөн хөрөнгө	0.3	3.4	13.6	2.1		2.5	0.2	0.6	1.1	0.0	23.8
Авлага	6.3	21.6	4.2	245.4			8.5	0.0			286.0
Урьдчилгаа							1.8				1.8
Бараа материал	13.7	29.1	4.2	350.5		41.3	0.7	2.0		1.0	442.5
Үндсэн хөрөнгө	126.7	345.5	2178.3	4556.6		0.8	840.8	3.0			8,051.7
Нийт хөрөнгийн дүн	147.0	399.6	2200.3	5154.6	0.0	44.6	852.0	5.6	1.1	1.0	8,805.8
Өр төлбөр	24.8	26.7	8.1	1140.9		41.6	17.0	6.0	0.8		1,265.9
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	122.2	372.9	2192.3	4013.7		3.0	835.0	-0.4	0.3	1.0	7,540.0
Өр төлбөр цэвэр	147.0	399.6	2200.4	5154.6	0.0	44.6	852.0	5.6	1.1	1.0	8,805.9

ОНӨААТҮГ нь нийт 8805.8 сая төгрөгний хөрөнгөтэйгээс мөнгөн хөрөнгө 23.8, авлага 286.0, урьдчилгаа 1.8, бараа материал 442.5, үндсэн хөрөнгө 8051.7 сая төгрөг байна.

14.2. ОН-ын өмчит байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн талаар :

- ✚ *Мянган Угалзат ОНӨААТҮГ нь авлага, өр төлбөрийг нэмэгдүүлсэн, үндсэн үйл ажиллагааны орлогоо бүрэн бүрдүүлээгүй, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг данс бүртгэлд тусгасан, жолоочийн тооцоо бодоогүй, шилэн дансны сайтад мэдээллийг бүрэн байршуулаагүй зэрэг зөрчилд төлбөрийн акт, албан шаардлага бичигдсэн.*
- ✚ *Шим ус ОНӨААТҮГ газар нь санхүүгийн тайланд тусгасан авлага, өглөгийг бүрэн баталгаажуулаагүй, орлогыг бүрэн хүлээн зөвшөөрч бүртгэснийг нотлох боломжгүй, худалдан авсан үндсэн хөрөнгийг орлогод аваагүй, үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг зөрүүтэй тооцсон, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар шатахууныг хувь хүнээр төлүүлэх төлбөрийн актыг байгууллагаас төлсөн, цех салбар бүрээр өртөг тооцоогүй, Шүүхийн шийдвэрээр үргүй зардал гаргасан, төлөвлөж батлагдаагүй зардлуудыг санхүүжүүлсэн, санхүүгийн программ хангамжийг бүрэн ашиглаагүй зэрэг зөрчилд албан шаардлага, зөвлөмж өгсөн.*

14.3 ОН-ийн ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн төсөл, сангийн талаар

ОН-ын ТЕЗ-ын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах сангууд нэгтгэгдсэн байна. Үүнд: Аймгийн өмчийн сан, Сум хөгжүүлэх сан, Хотын хөгжлийн төлөө сан, Эмийн эргэлтийн сан, Хөшөөт хөгжлийн сан зэрэг 57 сан нэгтгэгдсэн байна.

Сангуудын 2017 оны жилийн эцсийн мөнгө, авлага, өглөгийн үлдэгдэлийг хүснэгтээр харуулбал:

Аймгийн		/сая.төг /			
ДД	Сангийн нэр	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	Авлага	Өглөг
1	Аймгийн өмчийн сан / Ховд аймаг			119	
2	Сум хөгжүүлэх сан / 17 сум	277.6	383.8	4,617.30	14
3	Улсын төсвийн хөрөнгө оруулалт / Ховд аймаг			450.2	0
4	Орон нутгийн хөрөнгө оруулалт			422.1	
5	Эмийн эргэлтийн сан	2.1	4	7.9	53
6	Хөшөөт хөгжил сан	13.1	160.7	684.5	135.5
7	ОНХсан	263.4	443.7	2078.3	29.6
8	Халамжийн сан	2.4	0.2	0	0
9	Хотын хөгжлийн төлөө сан	17.1	4.2	2.9	0
	Нийт дүн	575.7	996.6	8382.2	232.1

байснаа оны эцэст 996.6 сая төгрөг болж өмнөх оноос 420.9 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт авлагын 55.0 хувь буюу 4617.3 сая төгрөгний авлага нь СХСангийн авлага эзлэж байгаа нь 2011 оноос улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр сумдад олгосон санхүүгийн эх үүсвэртэй холбоотой.

Сумдад жижиг дунд үйлдвэрлэл шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох зорилготой СХСангийн үйл ажиллагааны бүртгэл хөтлөлт, зээлийн авлага, хүүгийн авлагыг сум бүрээс 2011 оноос эхлэсэн тооцооны хүснэгтээр үргэлжлүүлэн авч хэвшсэн нь манай аймгийн аудитын газрын ажлын үр дүнгээс шалтгаалан өнөөдөр тус сан 4617.3 сая төгрөгний санхүүгийн эх үүсвэртэй болсонтой байна.

14.4 Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын талаар

- ✚ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны тогтоолын дагуу жижиг дунд үйлдвэрлэл хөгжсөн байдал, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, өмнөх жилийн зээлийн ашиглалт, зээл авах хэрэгцээ шаардлага зэргийг харгалзан олгосон зээл, зориулалт бус, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл их байна.
- ✚ Орон нутгийн хөгжлийн сан болон УТХО, ОНХО-тын дансны авлага нь насжилт өндөртэй авлагууд байна.

Арван тав. ОН-ийн тусгай шилжүүлгийн талаар

Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Аймаг, Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол
- Ерөнхий боловсрол
- Соёлын үйлчилгээ
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ
- Газрын харилцаа, кадастр
- Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ
- Нийтийн биеийн тамир

Үүний дагуу ЭМС, ХАХНХС, БСШУС-ын төсөвт батлагдсан тусгай зориулалтын шилжүүлгийг орон нутагт байршилтай харьяа байгууллагуудад, нийт 40264.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасны дагуу олгосон байна. 2017 онд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн талаар хүснэгтээс харахад:

(сая.төгрөгөөр)

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтэд 40264.3 сая төгрөг батлагдсанаас 40266.3 сая төгрөгийг олгож 2.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Үзүүлэлт	Нийт дүн	Үүнээс:			
		БСШУС-ын сайд	ХАХНХ-ын сайд	ЭМС-ын сайд	ГХБХБ
Батлагдсан төсөв	40,264.3	34,673.9	311.5	5,036.5	242.4
Олгосон урсгал санхүүжилт	40,266.3	34,673.5	311.5	5,038.9	242.4
Нийт төвлөрүүлсэн		-			-
Үүнээс: Төсөвт /Сангийн яам/		-			-

Тусгай зориулалтын төсвийн байгууллагуудын нийт хөрөнгө эх үүсвэрүүд аймгийн нийт хөрөнгө, эх үүсвэрийн 51,2 хувь буву 66625,0 сая төгрөгийг эзлэж байна. Үүнээс үндсэн хөрөнгө 96,1 хувь , эргэлтийн хөрөнгө 3,9 хувийг эзлэж байна.

Арван зургаа. ОН-ийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар

ОН-ийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэдэг орон нутгаас санхүүждэг аудитад хамрагдвал зохих 218 байгууллагаас 216 байгууллага аудитад хамрагдан 52 байгууллагыг түүвэрлэн хянаж, 6 байгууллагад итгэл үзүүлж, 158 байгууллагад дүгнэлт гаргасан байна. Чандмань БИТ, Эе эвийн хүч ОНӨААТҮГ-ын удирдлага солигдсон, үйл ажиллагаа явуулаагүйгээс аудитад хамрагдаагүй байна.

Орон нутгийн төвлөрүүлэн захирагч, 28 орон нутгийн өмчийн болон өмчийн оролцоотой ААН, 134 төсвийн шууд захирагч, 36 тусгай сангийн 2017 оны санхүүгийн тайланд аудит	№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн тоо	Аудитад хамрагдвал зохих	Үүнээс			Дүгнэлтийн хэлбэр		
					Аудитад хамрагдаж дүгнэлт гаргуулсан	Итгэл үзүүлсэн Түүвэрт	Аудит хийгдээгүй	Бүгд тоо	Зөрчилгүй Хязгаарлалттай	Сөрөг
	1	Төсвийн шууд захирагч	137	137	115	5	17	115	76	39
	2	Төсвийн төвлөрүүлэн захирагч	17	17	17			17	9	5 3
	3	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж /ЭЭСан, өрхийн эмнэлэгүүд/	28	28	25	1	35	2	25	10 14 1
	4	Орон нутгийн тусгай сан	36	36	1			1	1	
			218	218	158	6	52	2	158	96 58 4 0

хийж 6 тэрбум 531 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1 тэрбум 345.0 сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, 4 тэрбум 71.0 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг арилгуулах зөвлөмж өгч, 90.0 сая төгрөгийн 49 акт, 1 тэрбум 126 сая төгрөгийн 39 албан шаардлага бичсэн байна.

Аудитаар ОН-ийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн 96 тайланд зөрчилгүй, 58 тайланд хязгаарлалттай, 4 тайланд сөрөг санал дүгнэлт өгсөн нь өмнөх оноос хязгаарлалттай дүгнэлтийн тоо 18-аар, сөрөг дүгнэлтийн тоо 4-өөр тус нэмэгдсэн нь төсвийн байгууллагуудыг нягтлан бодох бүртгэлийн болон тайлагналын стандарт өмнөх оноос буурсан байна.

Санхүүгийн тайланд нэгтгэсэн байгууллага, нэгжийн ангилал	Алдаа, зөрчлийн ангилал											
	Аудитаар өгсөн зөвлөмж		Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн залруулга		Аудитын явцад тогтоосон төлбөрийн акт		Аудитын явцад өгсөн албан шаардлага		Албан тушаалтанд хариуцлага тооцуула		Аудитын илэрсэн нийт алдаа, зөрчлийн дүн	
	Тоо	Дүн /сая.төг/	Тоо	Дүн /сая.төг/	Тоо	Дүн /сая.төг/	Тоо	Дүн /сая.төг/	Тоо	Дүн /сая.төг/	Тоо	Дүн /сая.төг/
ТШЗ	236	1163.8	64	622.9	34	27.3	29	185.2	39	402	2039.1	
ТТЗ	67	2561.1	20	261.2	13	60.8	7	739.3	8	115	3622.4	
ОНӨААТҮГ	27	345.8	15	321.3	2	1.5	2	132.7	15	61	801.4	
	330	4070.7	99	1205.4	49	89.6	38	1057.2	62	0	578 6462.9	

Орон нутгийн 17 төсвийн төвлөрүүлэн захирагч, 28 орон нутгийн өмчийн болон өмчийн оролцоотой ААН, 115 төсвийн шууд захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд аудит хийж 6 тэрбум 462.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1 тэрбум

205.4 сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, 4 тэрбум 70.7 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг арилгуулах зөвлөмж өгч, 89.6 сая төгрөгийн 49 акт, 1 тэрбум 57.2 сая төгрөгийн 38 албан шаардлага бичсэн байна. Илэрсэн алдаа зөрчлийн 56 хувийг буюу 3 тэрбум 622.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг 17 сумын ТТЗ-ийн байгууллагын тайлангуудад илэрсэн байгаа нь ТТЗ-ын байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

Арван долоо. Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн санал, дүгнэлт

